

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР БАТЛАГДСАН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ /2019 оны эхний хагас жилийн байдлаар/

2019 оны 06 дугаар сарын 26-ны өдөр

№	Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	3	4	5	6
САЛБАР ЧИГЛЭЛ: 1. ГЕОЛОГИ, ЭРДЭС БАЯЛГИЙН БОДЛОГО						
<i>1.а. Монгол Улсын хууль</i>						
<i>1.б. УИХ-ын тогтоол</i>						
<i>1.в. УИХ-ын Байнгын хорооны тогтоол</i>						
<i>1.г. Ерөнхийлөгчийн зарлиг</i>						
<i>1.д. ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл</i>						
<i>1.е. Засгийн газрын тогтоол</i>						
1	1	1	2017_149. ХӨРС ХАМГААЛАХ ӨДӨРТЭЙ БОЛОХ ТУХАЙ / 2017-05-24 / 3. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан арга хэмжээг улсын болон тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж, жил бүрийн 12 дугаар сард нэгтгэн дүгнэж байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	Жил бүрийн 5 дугаар сарын эхний 7 хоногийн Бямба гарагийг "Хөрс хамгаалах үндэсний өдөр" болгон тэмдэглэн өнгөрүүлэх бөгөөд АМГТГ-тай хамтран зохион байгуулан ажиллаж байна.	100	

			Д.Оюунхорол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурь, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.			
2	2	2	2018_301. ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХ ЗАРИМ ТАЛБАЙН СОЛБИЦОЛ БАТЛАХ ТУХАЙ /2018-10-03/ 3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай.	“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн Багц 3 буюу Хашаатын даваа-Толбо нуур чиглэлийн 60км хатуу хучилттай автозамын барилгын ажлын үед замын далан, гүүр болон бусад туслах материалаар ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмал болох дайрганы чулуу, элс шавар зэрэг ашигт малтмалыг ашиглах талбайн хил заагийг энэхүү тогтоолоор зааж өгсөн байна. Энэхүү замын барилгын ажилд дээрх талбайгаас түгээмэл тархацтай ашигт малтмалуудыг ашиглаж буй бөгөөд 2018 оны жилийн эцсийн байдлаар замын ажлын гүйцэтгэл 56%-тай, байна. Урьдчилсан байдлаар Хашаатын даваа-Толбо нуур чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замыг 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр хүлээж авахаар төлөвлөж байна.	100	
3	3	3	2019_112. УЛААНБААТАР-ДАРХАН ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМЫН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ /2019-03-21/ 3.. Авто замын барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох асуудлыг зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт үүрэг болгосугай.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолоор баталсан “Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай журам”-ын 1.3.2, 1.4-т заасныг тус тус үндэслэн тус яамнаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын өргөтгөл, шинэчлэлт, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжих Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн бүтээн байгуулалтын ажилд тус тус шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлуудыг Засгийн газрын хуралдааны 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 184 дүгээр тогтоолоор батлуулсан.	100	
4	4	4	2019_176. ТӨСЛИЙН НЭГЖ БАЙГУУЛАХ ТУХАЙ /2019-05-01/	“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ын тогтоолоор байгуулан холбогдох ажлыг зохион байгуулж байна.	30	

			1.. Газрын ховор элементийн хайгуул, олборлолт, ашиглалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, нөөц нь бүртгэгдсэн ордын эдийн засгийн үр ашгийн тооцоог гүйцэтгэх, тэдгээрийг өндөр хөгжилтэй орнуудтай хамтран ашиглаж эдийн засгийн эргэлтэд оруулах үүрэг бүхий төслийн нэгжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай.			
5	4	5	3.. Төслийн нэгжийг 5 жилийн хугацаатай ажиллуулж, үр дүнгийн тайланг тухайн жилийн 12 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, “Эрдэнэс Монгол” ХХК (П.Ганхүү)-д даалгасугай.	“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ын тогтоолоор байгуулан холбогдох ажлыг зохион байгуулж байна.	30	
6	5	6	2019_188. ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ТӨСЛИЙН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ /2019-05-12/ 2.. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн бүтээн байгуулалтын ажилд шаардагдах ус, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрөөс чөлөөлөх асуудлыг судалж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат нарт даалгасугай.	Монгол Улсын Засгийн Газраас 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 135 дугаар тогтоолын дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн нүүрсний ордоос Дорноговь аймгийн Зүүнбаян өртөө хүртэл нийт 414.6 км Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн эргэлтийн цэг, солбицлын төслийг боловсруулж, 2019 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 189 дүгээр тогтоолоор батлуулсан.	70	
1.ё. Ерөнхий сайдын захирамж						
1.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл						
7	1	1	2018_50. 2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 5-НЫ ӨДӨР 50 ДУГААР ТЭМДЭГЛЭЛ /2018-12-05 / IX.3. Үндэсний гео мэдээллийн сан хөтөлбөрийн талаар Уул уурхай, хүнд	“Үндэсний геомэдээллийн сан” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 177 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөр батлагдсантай холбогдуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг	100	Тэмдэглэлийн дагуу холбогдох арга

			<p>Үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын нутаг дэвсгэрийн геологи-ашигт малтмалын шинэ мэдээллээр тогтмол баяжуулан хөтлөх замаар үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзээд “Үндэсний геомэдээллийн сан” хөтөлбөрийн төслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулан 2018 онд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул, уурхай хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав.</p>	<p>салбар хоорондын уялдааг ханган боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/95 дугаар тушаалаар батлуулан ажиллаж байна.</p>	<p>хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.</p>	
8	2	2	<p>2019_2. 2019 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН 9-НИЙ ӨДӨР 2 ДУГААР ТЭМДЭГЛЭЛ /2019-01-09/</p> <p>ХХIII.5. “Газрын ховор элемент” хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав.</p>	<p>Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журамд нийцүүлэн хөтөлбөрийн төслийг 3 сард боловсруулсан. Үүнтэй холбогдуулан хэтийн төлөвийн судалгаануудыг хийж байна.</p>	30	
9	3	3	<p>2019_4. 2019 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН 16-НЫ ӨДӨР 4 ДҮГЭЭР ТЭМДЭГЛЭЛ /2019-01-16/</p> <p>XII.1. Стратегийн ач холбогдолтой том төслийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан стратегийн ач холбогдолтой том төслүүдийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай танилцуулгыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд оруулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав.</p>	<p>Засгийн газраас өгсөн үүргийн дагуу стратегийн ач холбогдол бүхий газрын ховор элемент, уран, алт зэрэг ашигт малтмалын талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг бэлтгэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд 4 сард танилцуулсан /нууцын зэрэглэлтэй/.</p>	70	
10	4	4	<p>2014_51. 2014 ОНЫ 10 ДУГААР САРЫН 4-НИЙ ӨДӨР 51 ДҮГЭЭР ТЭМДЭГЛЭЛ /2014-10-04/</p> <p>ХҮI. Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг зөвшөөрч, холбогдох хуулийн</p>	<p>Уул уурхайн сайд Р.Жигжидийн 2015 оны 01 дүгээр 08-ны өдрийн 03 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан. Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг тухайн ажлын хэсгээс боловсруулан батлуулж, хуулийн төслийг боловсруулсан. Монгол Улсын Засгийн газрын</p>	/-/	

			дагуу үзэл баримтлалыг батлуулан хуулийн төслийг боловсруулж танилцуулах өргөтгөсөн ажлын хэсэг гарган ажиллуулахыг Уул уурхайн сайд Д.Ганхуягт даалгав.	2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт энэ асуудал дахин туссанаар Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/209 дугаар тушаалаар шинээр байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд салбарын яамнаас гадна Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Байгаль орчин аялал, жуулчлалын яам, Барилга, хот байгуулалтын яам, Зам тээвэр, хөгжлийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, холбогдох агентлагууд болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг хамруулан өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулсан. Ажлын хэсэг нь хууль эрх зүйн орчин, хуулийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны ажил хийж байна. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь Хууль эрх зүй, дотоод хэргийн яаманд хандан Газрын хэвлийн тухай хуулийн давхцал, зөрчил, хийдлийн судалгааг хийлгэсэн. Судалгааг хийсэн хуульчдын багтай хуулийн үйлчлэлийн тухай асуудлаар ажлын уулзалтуудыг удаа хийж, судалгааг дахин хийлгэсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд бүтцийн өөрчлөлт хийгдсэнтэй уялдуулан Ажлын хэсгийг шинээр байгуулах шаардлагатай болсон. Ажлын хэсгийг шинээр байгуулах бэлтгэл ажлыг хийж байна.		
Хэсгийн дундаж: 70%						
САЛБАР ЧИГЛЭЛ: 2. ГАЗРЫН ТОС, ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН НӨӨЦИЙН ТАЛААРХ БОДЛОГО						
2.а. Монгол Улсын хууль						
11	1	1	ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2014-07-01/2014_06. 8.1.3. газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага; газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага; газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага; гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай; газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн	1. "Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага" журмын төслийг боловсруулах ажлыг MINIS төслөөс санхүүжүүлэхээр шийдвэрлүүлж, ажлын даалгаврыг боловсруулан MINIS төсөлд хүргүүлсэн бөгөөд уг төслөөс тус журмыг боловсруулах аж ахуйн нэгжийг сонгох сонгон шалгаруулалтыг 2019 оны 06 дугаар сард багтаан зарлах гэж байна. 2. "Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага" журмыг Уул уурхайн сайд /хуучин нэрээр/-ын 2015.03.10-ны 49 дүгээр тушаалаар батлуулан мөрдөж байна.	100	

			<p>авах; газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журмыг батлах;</p> <p>3. “Газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага” журмын төслийг боловсруулж, салбарын мэргэжлийн холбоод, холбогдох байгууллагаас санал авч тусган 2015.02.06-ны өдрийн Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Уул уурхайн сайд /хуучин нэрээр/-ын 2015.09.04-ний өдрийн 197 дугаар тушаалаар батлуулсан хэдий ч Захиргааны ерөнхий хууль батлагдсантай холбогдуулан тус хуульд нийцүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас буцаагдсан тул уг журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018.01.10-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлуулан мөрдөж байна.</p> <p>4. "Гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай журам"-ыг Уул уурхайн сайд /хуучин нэрээр/-ын 2014 оны 202 дугаар тушаалаар батлуулан мөрдөж байна.</p> <p>5. “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах” журмыг боловсруулж, салбарын мэргэжлийн холбоод, холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн Уул уурхайн сайд /хуучин нэрээр/-ын 2015.02.06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн Уул уурхайн сайд /хуучин нэрээр/-ын 2015.09.04-ний өдрийн 196 дугаар тушаалаар батлуулсан хэдий ч Захиргааны ерөнхий хууль батлагдсантай холбогдуулан тус хуульд нийцүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас буцаагдсан тул уг журмын төслийг Захиргааны хуульд нийцүүлэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018.01.10-ны өдрийн А/06-р тушаалаар батлуулан мөрдөж байна.</p> <p>6. "Газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журам"-ыг Уул уурхайн сайд /хуучин нэрээр/-ын 2015.03.12-ны өдрийн 53-р тушаалаар батлуулсан.</p> <p>Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагалдан гарсан дээрх журмуудыг УУХҮЯ-ны /www.mmhi.gov.mn/ цахим хуудсанд байршуулсан.</p>		
12	1	2	<p>8.1.8. газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журмыг</p> <p>“Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журам”-ыг УУХҮСайд болон БОАЖСайд нарын 2018.02.22-ны өдрийн А/50, А/31 дугаар хамтарсан тушаалаар батлуулж, Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх</p>	100	

			байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;	Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2018.03.06-ны өдрийн 3870 дугаарт бүртгүүлсэн. “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журам”-ын хэрэгжилтийг хангуулан, холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллах тухай 03/655 тоот албан бичгийг 2018.03.12-ны өдөр АМГТГ-т хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.		
13	1	3	8.1.9. газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм батлах;	АМГТГ-аас боловсруулж ирүүлсэн “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийн төслийг иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулж, санал шүүмж авах хэлэлцүүлгийг Нээлттэй нийгэм форумтай хамтран 2018.03.21-ний өдөр зохион байгуулж, санал авсан. Энэхүү дүрмийн орчуулгын эх хувь болох ОХУ-ын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм 2018 онд шинэчлэгдсэн, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо MNS JIS 45001-2018 45х Үндэсний стандарт 2018 онд батлагдсан, мөн газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа гадаад, дотоодын аж ахуйн нэгжүүдийн мөрдөн ажиллаж буй олон улсын стандартуудыг дүрмийн төсөлд тусгах, уялдуулах, дүрмийн бүтэц, агуулгыг сайжруулах зэрэгтэй холбоотойгоор өргөн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж, дүрмийн төслийг шинэчлэн боловсруулах шаардлагатай байгаа тул холбогдох ажлууд хийгдэж байна.	70	
2.б. УИХ-ын тогтоол						
14	1	1	2017 №69. МОНГОЛ УЛСЫН 201& ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ / 2016-11-17 / 1.2.2. түүхий нефтийн экспортоос нөөц ашигласны төлбөрийг тооцож авах, борлуулалтын орлогыг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх хуулийн шаардлагыг бүтээгдэхүүн хуваах гэрээнд тусгах гэрээ	“Газрын тосны нөөц ашигласны төлбөр, тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам”-ыг боловсруулан Монгол Улсын Засгийн газрын 2018.01.03-ны өдрийн 5 дугаар тогтоолоор батлуулан мөрдөж ажиллаж байна. Газрын тосны борлуулалтын орлогоос нөөц ашигласны төлбөрийг тооцож 2017 онд 31.7 тэрбум төгрөг, 2018 онд 33.5 тэрбум төгрөгийг тус тус улсын төсөвт төвлөрүүлсэн. Газрын тосны тухай хуулийн 11.2.6 дугаар зүйлд “хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан	100	

			хэлцлийг хийж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах.	гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгах” гэсэн заалтыг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 03 дугаар сарын 104 дүгээр тогтоолоор загвар Бүтээгдэхүүн хуваах гэрээний 15 дугаар зүйлд тусган баталгаажуулсан. Загвар гэрээний дагуу газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж буй 11 компаний БХГ-г шинэчлэн баталж, гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байна.		
<i>2.в. УИХ-ын Байнгын хорооны тогтоол</i>						
<i>2.г. Ерөнхийлөгчийн зарлиг</i>						
<i>2.д. ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл</i>						
15	1	1	<p style="text-align: center;">2014_14/06. ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ /2014-03-17/</p> <p>1. Стратегийн чухал ач холбогдолтой газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдийг түшиглэн байгуулах</p>	<p>Засгийн газрын 2017.03.20-ны өдрийн “Төрийн өмчит компани байгуулах тухай” 92 дугаар тогтоолоор “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийг хэрэгжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий 100 хувь төрийн өмчит компани байгуулахаар шийдвэрлэж улмаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017.04.04-ний өдрийн 108 дугаар тогтоолоор “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулсан. Засгийн газрын 2017.02.17-ны өдрийн “Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн тухай” 59 дүгээр тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт /Эксим/ банк хоорондын Зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Засгийн газрын 2017.03.20-ны өдрийн “Төрийн өмчит компани байгуулах тухай” 92 дугаар тогтоолоор “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийг хэрэгжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий 100 хувь төрийн өмчит компани байгуулахаар шийдвэрлэсэн. Дээрх тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017.04.04-ний өдрийн 108 дугаар тогтоолоор “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулсан. “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийг Монгол Улсын Засгийн газарт БНЭУ-ын Экспорт-Импорт</p>	100	

			<p>бангаар дамжуулан олгох 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх хуулийг Их хурал 2017.05.31-ний өдөр соёрхон баталсан. Засгийн газрын 2018.01.24-ний өдрийн “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын талаар авах арга хэмжээний тухай” 21 дүгээр тогтоолоор “Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр” чиглэлийн салаа төмөр зам, хүнд даацын тусгай зориулалттай автозам, цахилгаан дамжуулах агаарын шугам барих төслүүдийг хэрэгжүүлэхийг Батлан хамгаалахын сайд, Зам, тээвэр хөгжлийн сайд, Эрчим хүчний сайд нарт даалгасан. Засгийн газрын 2018.01.24-ний өдрийн “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” 28 дугаар тогтоолоор Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутаг дэвсгэрт орших 150 га газрыг томоохон бүтээн байгуулалтын төсөл болох “газрын тос боловсруулах үйлдвэр” байгуулах зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан. Засгийн газрын 2018.01.03-ны өдрийн “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2 дугаар тогтоолоор боловсруулах үйлдвэрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Монгол Улсын Хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлж, төмөр зам, автозам, цахилгаан дамжуулах агаарын шугам, үйлдвэрийн талбайн газар шорооны ажлуудыг 2018 оны эхний хагас жилд багтаан эхлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Зам, тээвэр хөгжлийн сайд, Эрчим хүчний сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан. Үйлдвэр байгуулахад шаардлагатай гаднах дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд болох “Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр” чиглэлийн 27 км урт салаа төмөр зам, 18.2 км, 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/10 кВ-ын 6.3 МВ-ын суурилагдсан хүчин чадал бүхий дэд станц болон 16.63 км урт хатуу хучилттай автозам барих төслүүдийн барилга угсралтын ажлыг 2018.06.22-ны өдөр Дорноговь аймгийн Алтанширээ суманд эхлүүлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар барилга угсралтын ажлын явц 90 гаруй хувийн гүйцэтгэлтэй байна. Дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлуудыг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ашиглалтад хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.</p>		
--	--	--	--	--	--

16	2	2	<p>2014_52/30. АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ /2014-10-20/</p> <p>2.5. Нүүрсийг гүн боловсруулах /шингэрүүлэх, хийжүүлэх/, нүүрсний давхаргын метан хийг олборлох технологийг нэвтрүүлж, цэвэр түлш үйлдвэрлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрийг сонгон хэрэгжүүлэх</p>	<p>Засгийн газрын 2014 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 74 дүгээр тогтоолоор “БНХАУ-ын Синопек корпорацийтай хамтран нүүрсийг хийжүүлэх технологи нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий” төслийн нэгжийг Уул уурхай яамны дэргэд байгуулсан. Тус төслийн нэгж Багануурын уурхайг түшиглэн 1-3 тэрбум шоо м3 синтетик хий үйлдвэрлэх үйлдвэр барих техник, эдийн засгийн урьдчилсан судалгааг БНХАУ-ын Синопек компанитай хамтран хийсэн. Судалгааны дүнгээр Багануурын нүүрс нь чанарын хувьд хангалттай сайн биш, үйлдвэрийг Багануурын нүүрсний уурхайг түшиглэн барих нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болохыг тодорхойлсон. урьдчилсан ТЭЗҮ-д үндэслэн Цайдамнуурын болон Эрдэнэцогтын уурхай дээр тус бүр жилийн 8 тэрбум шоо м3 хүчин чадалтай нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих нарийвчилсан ТЭЗҮ-ийн судалгааг хийх байсан боловч санхүүжилт шийдэгдээгүй учир зогссон. Төслийн нэгж БНХАУ-ын Хийн хоолойн зураг төслийн байгууллагуудтай хамтран 2015 оны 3-7 дугаар сарын хооронд Улаанбаатар хотын гэр хорооллыг нүүрсний хийгээр хангах үйлдвэрийн ТЭЗҮ болон нүүрсний хий дамжуулах хоолойн байгууламжийн ТЭЗҮ-ийг боловсруулж, БНХАУ-ын Хөгжил шинэтгэлийн хорооноос үйлдвэр барихаар санал болгосон 3 компанийн дунд сонгон шалгаруулалт зарлахаар холбогдох бэлтгэл ажлуудыг хангасан. Засгийн газрын 2015 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 309 дүгээр тогтоолоор уг төслийн санхүүжилтийг “Улаанбаатар Хөшигтийн хөндийн хурдны зам барих төсөл”, “Туул гол дээгүүр яван өнгөрөх Баянзүрхийн 288 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүрийг шинээр барих төсөл”-д олгохоор шийдвэрлэсэн. Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 29-ны өдрийн 131 дугаар тогтоолоор тус төслийн нэгжийг татан буулгасан. Монгол улс нүүрсний давхаргын метан хийн ихээхэн хэмжээний (17-43 триллион шоо метр) нөөцтэй байж болох талаар судлаачдын гаргасан судалгаа бий бөгөөд БНСУ-ын КОГАЗ, Австралийн Голден Хорд болон Нордик Гео Солюшн, Элгэн зэрэг компаниудын хийсэн судалгааны тайланд Таван Толгойн ордын нүүрсний давхаргын метан хийн нөөцийг урьдчилсан төсөөллөөр 40 сая.тн буюу 4.7 тэрбум шоо метр гэж тогтоосон байдаг.</p>	30	
----	---	---	--	--	----	--

				Нүүрсний давхаргын метан хийн хуримтлалын эрэл, хайгуул, судалгааны ажил хийж гүйцэтгэх, метан хийн нөөц тогтоохтой холбоотой санал санаачлага, төсөл хөтөлбөрийг дэмжин ажиллаж байгаа ба газрын тосны хайгуулын Номгон-IX талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуул, судалгааны ажил хийж гүйцэтгэх тухай Бүтээгдэхүүн хуваах гэрээг АМГТГ болон Австрали улсын хөрөнгө оруулалттай “Жи Өү Эйч” ХХК-ийн хооронд 2018.09.18-ны өдөр байгуулсан. БНХАУ, ОХУ-аас байгалийн хий импортлон, нийтийн тээврийн хэрэгслийг хийн түлшээр хангах төсөл хэрэгжүүлэн ажиллаж байгаа “Ю Би Метан” ХХК-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгалийн хий импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, тус компани нь нийтийн тээврийн 100 гаруй хэрэгслийг байгалийн хийн түлшээр ханган ажиллаж байна. Шингэрүүлсэн шатдаг хийн түлшний салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, стандарт, норм дүрэм, журмыг боловсруулах ажлын хүрээнд шингэрүүлсэн шатдаг хийн талаарх АНУ-ын NFPA-58 стандартад тулгуурлан боловсруулсан Үндэсний стандартын төслийг хянан нэр бүхий 12 байгууллагаас санал авч нэгтгэн хэлэлцүүлэг хийх бэлтгэл ажлыг хангаж байна.		
<i>2.е. Засгийн газрын тогтоол</i>						
17	1	1	2018_169. ТӨРӨӨС ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО БАТЛАХ ТУХАЙ /2018-06-06 / 2. “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай.	Монгол Улсын Засгийн газрын 2018.06.06-ны өдрийн 169 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар 2027 он хүртэл баримтлах бодлого”-ын төлөвлөгөөг боловсруулж, Канадын Мерит төслийн зөвлөх Рэймонд Жирвэйсээс санал авахаар хамтран ажиллаж байна.	30	
18	1	2	3. “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж,	2019 онд газрын тосны орлогоос 335 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар 2027 он хүртэл баримтлах бодлого”-ын баримт бичигт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх талаар үйл ажиллагааны төлөвлөгөө	30	

			гадаадын зээл, тусламжид хамруулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	боловсруулж 2020 оны Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгахаар төлөвлөн ажиллаж байна.		
19	2	3	<p>2018_322. ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ ТУХАЙ / 2018-10-24 /</p> <p>2. Энэ тогтоолын хавсралтад заасан газрын тосны бүтээгдэхүүний компаний нөөцийг 2019 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор бүрдүүлэх арга хэмжээ авч, нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д. Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн нарт даалгасугай.</p>	Засгийн газрын 2012.11.27-ны өдрийн 126 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын тосны бүтээгдэхүүн импортоор оруулж, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлж байгаа компанийн нөөц бүрдүүлэх журам”-ын 7 дугаар заалтын дагуу “Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийн хэмжээг шинэчлэх тухай” ЗГ-ын тогтоолын төсөл болон 2019 онд газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх аж ахуйн нэгжүүдийн нэрсийн жагсаалт, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг танилцуулгын хамт нэгтгэн боловсруулж, 2018.10.24-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 322 дугаар тогтоолоор батлуулсан. Тогтоолын дагуу аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулж, нөөцийн бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллах үүргийг албан тоотоор АМГТГ-т хүргүүлсэн. 2019.01.29-ний өдөр газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл эзэмшигч 26 аж ахуйн нэгжтэй 116,5 мянган тонн компаний нөөц бүрдүүлэх талаар гэрээ байгуулсан. Дээрх аж ахуйн нэгжүүдийн нөөц бүрдүүлэх бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг агуулахын байршлаар нь нэгтгэн хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. 2019.06.11-ний өдрийн байдлаар улсын хэмжээнд дунджаар ердийн хэрэглээний 30 хоногийн буюу А-80 автобензин 51, Аи-92 автобензин 39, дизелийн түлш 23, ТС-1 онгоцны түлш 18 хоногийн нөөцтэй байна.	100	
			2.ё. Ерөнхий сайдын захирамж			
20	1	1	<p>2018_201. АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАХ ТУХАЙ /ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭГЧ БОЛОН ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БӨӨНИЙ, ЖИЖИГЛЭНГИЙН ХУДАЛДАА ЭРХЭЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН БҮТЭЭГДЭХҮҮНД ЧАНАРЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙЖ,</p>	Монгол Улсын Ерөнхий сайдын 2018.12.10-ны өдрийн 201 дүгээр захирамжийн дагуу байгуулагдсан ажлын хэсгийн ажлын хүрээнд Монгол Улсын Шадар Сайдын 2019.02.25-ны өдрийн 14 дугаар тушаалаар “Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүнд чанарын хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах” дэд ажлын хэсгийг СЯ, УУХҮЯ, БОАЖЯ, ТЕГ, ГЕГ, ОБЕГ, МХЕГ, АМГТГ, СХЗГ, ЦЕГ, МҮХАҮТ, “Улаанбаатар төмөр зам” ХНН, ШӨХТГ болон Монголын шатахуун эрхлэгчдийн холбооны	30	

			<p>ДҮГНЭЛТ ГАРГАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ / 2018-12-10 /</p> <p>2. Газрын тосны бүтээгдэхүүнд чанарын хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах асуудлаар дэд ажлын хэсэг байгуулан ажиллуулах, ажлын явцад хяналт тавьж, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэхийг Ажлын хэсэг (Ө.Энхтүвшин)-т даалгасугай.</p>	бүрэлдэхүүнтэй байгуулж, ажлын хэсгийн хуралдааныг 5 удаа зохион байгуулаад байна.		
<i>2.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл</i>						
21	1	1	<p>2017_14. 2017 ОНЫ 3 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДӨР 14 ДҮГЭЭР ТЭМДЭГЛЭЛ / 2017-03-29 /</p> <p>2. Нисэх онгоцны шинэ буудлыг агаарын хөлгийн ТС-1 болон Жет А-1 төрлийн шатахуунаар хангах хос байгууламжтай болгох, Дорноговь аймгийн Замын-Үүд суманд баригдаж байгаа Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжид агаарын хөлгийн шатахуун шилжүүлэн ачих технологийн шугамын өргөтгөл хийх замаар Жет А-1 төрлийн шатахуун импортоор оруулах боломжийг бүрдүүлэх асуудлыг судлан хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх саналаа Засгийн газарт танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт даалгав.</p>	Замын-Үүд боомтод агаарын хөлгийн шатахууныг импортлох асуудлаар 2017 оны 02, 03 дугаар саруудад Замын-Үүд дэх Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж /ШТШАБ/ ТӨҮГ, Иргэний нисэхийн ерөнхий газар /ИНЕГ/-ын уулзалтуудыг хийсэн. ИНЕГ, Замын-Үүд дэх ШТШАБ-ийн удирдлагуудтай хийсэн холбогдох уулзалтын хурлын шийдвэрийн дагуу АМГТГ, ИНЕГ-ын даргын 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/265, а/59 дугаар хамтарсан тушаалаар ШТШАБ-ийн өргөтгөлийн ажлын даалгавар боловсруулах, хяналт тавих, батлуулах, хүлээн авах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Уг ажлын хэсэг зургийн даалгавар боловсруулахтай холбогдуулан Замын-Үүд суманд 2017 оны 05 дугаар сарын 19-22-ний өдрүүдэд газар дээр нь очиж ажилласан бөгөөд ШТШАБ-ийг өргөтгөхтэй холбоотойгоор газрын хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай талаарх дүгнэлтийг гарган, шийдвэрлүүлэхээр тус аймгийн Засаг даргад хүсэлт хүргүүлсэн. Үүний үр дүнд байгууламжийн өргөтгөлд шаардлагатай газрын хэмжээг нэмэгдүүлэх асуудал Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэгдэж, тус хурлын 2017 оны 17 тоот тогтоолоор батлагдан, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Засаг даргын 2017.06.12-ны өдрийн А/163 дугаар захирамжаар “ЗҮ-ШТШАБ” ТӨҮГ-т 1 га газрыг 15 жилийн хугацаатай шинээр нэмж олгох шийдвэрийг гаргасан. Түүнчлэн ажлын хэсэг нэмж шинээр өргөтгөх хэсгийн сав, насос станц, технологийн шугам хоолой барих газрыг урьдчилсан байдлаар төлөвлөн, зургийн даалгавар боловсруулах ажлыг хийж гүйцэтгэн батлуулав. Дорноговь аймгийн Замын-Үүд суманд баригдаж байгаа Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжид агаарын	30	

				хөлгийн шатахуун шилжүүлэн ачих технологийн шугамын өргөтгөл хийх замаар Жет А-1 төрлийн шатахуун импортоор оруулах боломжийг бүрдүүлэх асуудлыг судалж, “ЗҮ-ШТШАБ” ТӨҮГ-аас хийлгэсэн зураг төсөл, төсвийн саналыг УУХҮЯ-ны Санхүүгийн хэлтэст танилцуулж, улсын төсөвт шаардагдах хөрөнгийг шийдвэрлүүлэхээр хандсан боловч санал дэмжигдээгүй болно.		
22	2	2	2018_20. 2018 ОНЫ 5 ДУГААР САРЫН 2-НЫ ӨДӨР 20 ДУГААР ТЭМДЭГЛЭЛ /2018-05-02 / 2. Газрын тосны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой үйл ажиллагааг бодлогын удирдамжаар ханган хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэнд тус тус үүрэг болгов.	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны талаарх танилцуулга мэдээллийг Засгийн газарт танилцуулж, үүний дагуу Монгол Улсын Засгийн газрын 2018.10.03-ны өдрийн хуралдаанаар 41 дүгээр тэмдэглэл гарсан. 41 дүгээр тэмдэглэлийн дагуу хийгдсэн ажлын талаар энэ хүснэгтийн 22 дугаар мөрөнд бичив.	70	
23	2	3	XXII.9.2. Засгийн газрын тухай хуулийн 20.5.12-т заасан эрхэлсэн асуудлын хүрээний дагуу газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын явц, гүйцэтгэл, зээлийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж, бодлогын болон мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт үүрэг болгов.	"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн өдөр тутмын үйл ажиллагаанд болон дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлийн тайланг гүйцэтгэгч компаниудаас долоо хоног бүр авч хяналт тавин ажиллаж байна. Мөн УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар "Газрын тос боловсруулах үйлдвэр болон дамжуулах хоолой барих төсөл"-ийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг 2018.11.15-ны өдөр хэлэлцэн хүлээн авахаар шийдвэрлэсэн. Засгийн газрын 2019.04.03-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд үйлдвэрийн ажилчдын орон сууцаар хангах зорилгоор Дорноговь аймгийн Сайншанд хотын нутаг дэвсгэрт 550 айлын орон сууцны хотхон байгуулах ажлыг зохион байгуулах, хотхоны бүтээн байгуулалтад шаардагдах бараа, материал тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулж 05 дугаар сард багтаан танилцуулахыг УУХҮСайд, Сангийн сайд нарт даалгасны дагуу гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас	100	

				чөлөөлөх тухай хуулийн үзэл баримтлалыг боловсруулан 2019.05.08-ны өдрийн 01/1357 тоот албан бичгээр Сангийн сайд болон ХЗДХ-ийн сайд нарт хүргүүлж, ХЗДХСайдын 2019.05.22-ний өдрийн 1/1-2352, Сангийн Сайдын 2019.05.27-ны 4/2-3417 тоот албан бичгүүдээр ирүүлсэн саналыг тусган холбогдох яамдад хүргүүлэн тус хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулах гэж байна. "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК болон Энэтхэг Улсын "Инженерс Индия Лимитед" төрийн өмчит компаниуд 2019.05.13-ны өдөр газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсантай холбогдуулан гэрээний нийт үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх төлбөрийг зөвлөх компанид олгох зөвшөөрлийг Энэтхэгийн Эксим банкинд хүргүүлэх тухай албан бичгийг 2019.06.07-ны өдөр Сангийн яаманд хүргүүлсэн. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, төслийн нэгжийн үйл ажиллагаа, үйлдвэр барихад шаардлагатай гаднах дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөлд Үндэсний аудитын газраас гүйцэтгэлийн аудит хийж байгаатай холбогдуулан холбогдох баримт бичгийн бүрдлийг ажлын хэсэгт 2019.06.07-ны өдөр хүргүүлсэн.		
24	2	4	XXII.9.3. Монгол Улсын Хөгжлийн банкнаас "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад зориулан "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-д олгох зээлийн санхүүжилтийг ирээдүйд бий болох хөрөнгөөр барьцаалах замаар олгох асуудлыг судлан шийдвэрлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), Хөгжлийн банкны гүйцэтгэх Б.Батбаяр нарт даалгав.	"Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад зориулан "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК болон Монгол Улсын Хөгжлийн банк хооронд ирээдүйд бий болох хөрөнгийг барьцаалан буцаан төлөх нөхцөлтэйгөөр 2018.04.13-ны өдрийн БГ-МГТ-ИХ 2018-44 дугаар "Барьцааны гэрээ" болон мөн өдрийн ЗГ-МГТ-3 2018-43 дугаар "Зээлийн гэрээ"-г тус тус байгуулан ажиллаж байна. Энэхүү зээлийн хөрөнгөөр "Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр" чиглэлийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэлийн дагуу үе шаттайгаар санхүүжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2019 оны 06 дугаар сарын байдлаар уг төсөлд "Хөгжлийн банк"-наас нийт 120 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.	100	
25	3	5	2018_29. 2018 ОНЫ 7 ДУГААР САРЫН 4-НИЙ ӨДӨР 29 ДҮГЭЭР ТЭМДЭГЛЭЛ /2018-07-04 /	Монгол Улсын Засгийн газрын 2018.07.04-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийн дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс чиглэл авсаны үндсэнд дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн тул Газрын тосны тухай	70	

			<p>ХИҮ. Газрын тосны хайгуулын Баянтүмэн-ХVII талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах талаар Газрын тосны газар (хуучин нэрээр) болон “Магнай трейд” ХХК-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийн эрх, үүргийг “Магнай трейд” ХХК-аас “Эм Ти ПЛО” ХХК-д бүхэлд нь шилжүүлэх тухай асуудлыг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс чиглэл авсны үндсэн дээр дахин хэлэлцүүлэхээр хойшлуулав. Үүнтэй холбогдуулан газрын тосны салбарт байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт, ашигт малтмалын салбарт олгосон хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан боловч үйл ажиллагаа явуулалгүй тусгай зөвшөөрөл (гэрчилгээ)-ийг бусдад шилжүүлж (худалдаж) байгаа асуудлыг шийдвэрлэх болон цаашид авах арга хэмжээний талаар тодорхой санал боловсруулан зохих журмын дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав.</p>	<p>хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д заасны дагуу газрын тосны хайгуулын Баянтүмэн-ХVII талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг “Магнай трейд” ХХК-иас “Эм Ти ПЛО” ХХК-д шилжүүлэх тухай танилцуулга, холбогдох бичиг баримтыг хүргүүлж, уг асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулах хүсэлтийг УУХҮСайдын 2019.02.12-ны өдрийн 01/371 тоот албан бичгээр Монгол Улсын Сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд хүргүүлсэн.</p>		
26	4	6	<p>2018_41. 2018 ОНЫ 10 ДУГААР САРЫН 3-НЫ ӨДӨР 41 ДҮГЭЭР ТЭМДЭГЛЭЛ /2018-10-03/</p> <p>ХХIII.6.Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан гэрээлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7-д заасны дагуу холбогдох байгууллагуудтай хамтарсан шалгалт хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд 2019 оны 3 дугаар сард танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав.</p> <p>2. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барихтай холбогдуулан газрын тосны салбарын талаарх мэдээллийг олон нийтэд</p>	<p>1.БОАЖЯ, ЗТХЯ, МХЕГ, АМГТГ-ын төлөөлөл бүхий ажлын хэсгийг УУХҮСайдын 2018.12.03-ны өдрийн А/250 дугаар тушаалаар “Монгол Улсын Засгийн газрын 2018.10.03-ны өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэлийн 1 дүгээрт заасныг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан гэрээлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд шалгалт хийх” ажлын хэсгийг байгуулан ажиллаж, уг ажлын хэсгийн санал дүгнэлтийг УУХҮСайдын зөвлөлд 2019.03.14-ний өдөр танилцуулж, зөвлөлөөс гарсан шийдвэрийн дагуу 2019.03.29-ний өдрийн 01/840 тоот албан бичгээр Монгол Улсын Сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд холбогдох танилцуулга, тогтоолын төслийг хүргүүлсэн. Уг танилцуулгад цаашид авах доорх арга хэмжээг тусгасан. Үүнд:</p>	70	

			<p>сурталчлах, газрын тосны эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлж нөөц өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн нарт үүрэг болгов.” гэжээ.</p>	<ul style="list-style-type: none"> - Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барихтай холбогдуулан газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллах, - Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хууль бусаар саад учруулсан этгээдэд холбогдох хуулийн дагуу тухай бүр хариуцлага тооцож ажиллах, - Бүтээгдэхүүн хуваах гэрээний үүргээ биелүүлээгүй буюу удаа дараа ноцтой зөрчсөн "Өмнөд Монголын газар нутгийн тос" ХХК-ийн газрын тосны хайгуулын Номгон IX талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцлах, - Улсын тусгай хамгаалалттай газар нутагт газрын тостой холбогдсон үйл ажиллагааг явуулах боломж нөхцөлийг судалж Засгийн газарт танилцуулах, - Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувийг газрын тосны олборлолт явуулж буй аймаг, суманд хуваарилах эрх зүйн зохицуулалтыг Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх, - Газрын тосны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд бүх шатны төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад хуулиар хүлээлгэсэн үүргийн биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулж ажиллах. <p>2.УУХҮСайдын 2018.12.12-ны өдрийн 01/3306 тоот албан бичгээр “дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барихтай холбогдуулан газрын тосны салбарын талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлах, газрын тосны эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлж, нөөц өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах” талаар төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тухай бүр яаманд мэдээлж байхыг АМГТГ-т мэдэгдэж, хяналт тавин ажиллаж байна.</p>		
27	5	7	<p>2018_44. 2018 ОНЫ 10 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР 44 ДҮГЭЭР ТЭМДЭГЛЭЛ /2018-10-24/</p>	<p>1. Үндэсний хөгжлийн газрын даргын 2019.05.29-ний өдрийн А-97 дугаар тушаалаар “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын шатахуун</p>	70	

			<p>ХХҮ1.7.1. ОХУ-ын Роснефть компанитай хийж байгаа хамтын ажиллагааны хэлэлцээг үргэлжлүүлж, газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөлд хамтран оролцох нөхцөл боломжийг судлан танилцуулах; 2. Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдах газрын тос боловсруулах үйлдвэрээс Тосон-Уул орд хүртэл газрын тос дамжуулах хоолойн техник, технологи болон санхүүжүүлтийн асуудлыг судлан танилцуулах; 3. Дотоодын зах зээлд нийлүүлэх автобензин, дизелийн түлшний нөөц, хангамжийг нэмэгдүүлэх, тогтворжуулах зорилгоор автобензин, дизелийн түлшний нөөцийн агуулахуудын багтаамжийг нэмэгдүүлэх, гаалийн баталгаат агуулах байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх; 4. Хөшигийн хөндийд баригдаж байгаа нисэх онгоцны шинэ буудлыг түлш, шатахуунаар хангах асуудлыг шийдвэрлэхэд гадаадын хөрөнгө оруулалт, оролцоог судлан танилцуулах.</p>	<p>хангамжийн байгууламжийн менежмент төсөл"-д Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Зам, тээврийн хөгжлийн яамнаас санал болгосон, мөн төслийг хэрэгжүүлэх сонирхлоо ирүүлсэн "Роснефть" ХК-тай концессийн гэрээний хэлэлцээрийг хийж, дүгнэлт гаргах" үүрэг бүхий ажлын хэсэг ҮХГ, УУХҮЯ, СЯ болон ЗТХЯ, ИНЕГ, АМГТГ-ын бүрэлдэхүүнтэй байгуулагдан ажиллаж байна.</p> <p>2. Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдах газрын тос боловсруулах үйлдвэрээс Тосон-Уул орд хүртэл түүхий тос дамжуулах хоолойг нарийвчилсан ТЭЗҮ-ээр тооцоолсон хөрөнгө оруулалтын зардлаас бага өртөгтэйгээр ОХУ болон БНХАУ-д хэрэглэгдэж байгаа уламжлалт технологийг ашиглан байгуулах санхүүжилтийн болон техникийн боломжийг шийдвэрлэхэд Засгийн газрын баталгаа зайлшгүй шаардлагатай байгаа тул Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн зүгээс түүхий тос дамжуулах хоолойн асуудлыг Засгийн газар болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулахаар бэлтгэж байна.</p> <p>3. Улаанбаатар хотын Рашаант өртөөнд байрлах улсын нөөцийн газрын тосны бүтээгдэхүүний агуулахын 5000м³-ийн багтаамжтай 9ш савны суурийн цутгалтын ажил 100 хувь хийгдсэн. Улсын нөөцийн агуулахын 671м салаа төмөр замын ажил 100 хувь хийгдээд байна.</p> <p>4. Хөшигийн хөндийд баригдаж байгаа нисэх онгоцны шинэ буудлыг түлш, шатахуунаар хангах асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд ОХУ-ын Роснефть компани санал ирүүлснийг судалж, дээрх ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.</p>		
Хэсгийн дундаж: 70.5%						
САЛБАР ЧИГЛЭЛ: 3. УУЛ УУРХАЙН БОДЛОГО						
3.а. Монгол Улсын хууль						
28	1	1	<p>ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА) /2013-01-31</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/80 дугаар тушаалаар "Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм", "Пиротехникийн хэрэгслийг импортлох, ашиглах дүрэм"-ийг шинэчлэн боловсруулах, "Монгол Улсын нутагт дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх</p>	70	

			10.1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн болон хадгалах байр, агуулах дахь аюулгүй ажиллагааны журмыг геологи, уул уурхайн болон батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн хяналтын төв байгууллагатай хамтран батална.	бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт"-ыг тус тус боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлуулсан. Ажлын хэсгийн хүрээнд дүрмийн төслийг боловсруулахаар "Эрдэнэт үйлдвэр" ХХК, "Багануур" ХК, "Оюутолгой" ХХК-ийн үйлдвэрлэлийн баазыг түшиглэн ажлын хэсэг вакуум орчинд ажиллан дүрмийн төслийг боловсруулсан. Мөн "Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"-ийн төслийг 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдөр УУХҮЯ-ны албан ёсны вэб сайт http://mmhi.gov.mn/public/forum/id/639 -д олон нийтийн санал авахаар байршуулсан ба төслийн хэлэлцүүлгийг Тэсэлгээний ажил, үйлчилгээ эрхлэгчдийн холбоотой хамтран 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Нийслэлийн захиргааны V байрны ХАБ Инновацийн төвийн хурлын танхимд 45 орчим оролцогчтойгоор зохион байгуулсан. "Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"-ийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр Засгийн газрын тогтоолын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг боловсруулсан. Мөн дүрмийн төслийн танилцуулга болон нөлөөллийн шинжилгээний тайланг боловсруулсан. Тогтоолын төсөлд санал авахаар яам, агентлагт хүргүүлэхээр бэлтгэж байна.		
29	2	2	АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ /2015-02-18 / 47 ² .2. Энэ хуулийн 47 ² .1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг Засгийн газар батална.	АМТХ-ийн төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн яамаар батлуулж яамдаас санал авсны үндсэн дээр Засгийн газрын 2018.10.24-ний хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж 2019.03.26-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн уг хуулийн төслийг батлуулсан.	100	
3.б. УИХ-ын тогтоол						
30	1	1	02_2010_39. ТАВАН ТОЛГОЙН НҮҮРСНИЙ ОРДЫГ АШИГЛАХ ЗАРИМ АСУУДЛЫН ТУХАЙ / 2010-07-07/ 1.2.б. б/хувьцааны 10 хүртэлх хувийг 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ба түүнээс өмнө улсын бүртгэлд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байгаа, татвар төлсөн үндэсний аж ахуйн нэгжүүдэд адил тэнцүү хэмжээгээр, нэрлэсэн үнээр худалдах;	2010 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ба түүнээс өмнө улсын бүртгэлд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байгаа, татвар төлсөн үндэсний аж ахуй нэгжүүдэд хувьцааны 10 хүртэлх хувийг худалдаж, нийт 29.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн. Гэвч хувьцааг ОУ-ын зах зээлд гаргах зэрэг хөдөлгөөн хийгдээгүй, аж ахуй нэгжүүд удаа дараа хүсэлт гаргасан учраас Засгийн газрын 2013 оны 132, 409 дүгээр тогтоолоор нийт 21.3 тэрбум төгрөгийг буцаан ААН-үүдэд шилжүүлсэн, 1 сая төгрөг авах хүсэлт	70	

			<p>гаргасан эмзэг бүлгийн хэсэг иргэдэд 1.7 тэрбум төгрөгийг олгож, 6.2 тэрбум төгрөг үлдсэн бөгөөд хувьцаа худалдсанаас төвлөрсөн хөрөнгийг арилжааны банкинд хадгалсаны хүүгийн төлбөр 1.7 тэрбум төгрөгийн хамт нийт 7.9 тэрбум төгрөгийг Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.1.1-т заасны дагуу тус санд төвлөрүүлсэн.</p> <p>Засгийн газрын 2017 оны 154 дугаар "Эрдэнэс Монгол" ХХК болон түүний охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Сангийн яам, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлтэй, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн бүртгэл дэх хувьцаа эзэмшигчийн мэдээллийг тулгаж бүртгэсэн дүнгээр нийт 486 аж ахуйн нэгж 7,065,038 ширхэг хувьцаа буюу "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн нийт хувьцааны 0.05 хувийг эзэмшиж байна. "Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" УИХ-ын 2018 оны 73 дугаар тогтоолоор тус ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татсаны үндсэн дээр Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх хүрээнд холбогдох дэд бүтцийн болон шаардлагатай бусад төсөл, хөтөлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, УИХ, ЗГ-аас "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийг олон улсын зах зээлд IPO гаргах үүргийг өгснөөс хойш ордыг ашиглах ТЭЗҮ-ийг боловсруулж, дэд бүтцийн төслүүдийн тооцоо, судалгааг хийх ажлуудыг зохион байгуулаад байна.</p>		
31	1	2	<p>1.2.в. хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр худалдаж шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах;</p> <p>Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоолоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааг иргэн, аж ахуйн нэгжийн хооронд худалдах, худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд тус компанийн 1072 хувьцааг 1 сая төгрөгтэй дүйцүүлэн тухайн хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тогтоосон. Харин Засгийн газрын 2016 оны 316 дугаар тогтоолоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааны хоёрдахь зах зээлийн арилжаа эхлэх хүртэл хугацаанд дээрх хувьцааг саналын эрхгүй, Засгийн газарт нэрлэсэн үнээр нь худалдахаас бусад тохиолдолд аливаа</p>	70	

65	5	5	2017_31. 2017 ОНЫ 6 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР 31 ДҮГЭЭР ТЭМДЭГЛЭЛ /2017-06-28/ ХI.3. Дэлхийн банк болон Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газрын зээлсэн зээлийн өр төлбөрөөс “Багануур” ХК болон “Шивээ-Овоо” ХК-ийг чөлөөлөх асуудлыг судлан санал боловсруулж танилцуулахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний сайд П.Ганхүү, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Түмэнцогт нарт даалгав.	Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 187 дугаар тогтоол, Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 31 дүгээр хуралдааны тэмдэглэлийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх зорилгоор стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшигч “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн үйл ажиллагаа, санхүү эдийн засгийн байдалтай танилцах, хүндрэлтэй асуудлыг судалж, шийдвэрлэх талаар холбогдох санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Сангийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Эрчим хүчний сайдын хамтарсан тушаалаар байгуулах саналыг боловсруулж 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдөр УУХҮСайд Ц.Дашдоржид танилцуулсан бөгөөд Ажлын хэсгийн хүрээнд асуудлыг шийдвэрлэхээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Мөн Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банкны хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад “Багануурын уурхайн техник, технологийн шинэчлэлтийн төсөл”, “Шивээ-Овоогийн уурхайн техник, технологийн шинэчлэлтийн төсөл”-ийг хамруулах тухай хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлсэн.	70	

66	6	6	<p>2017_36. 2017 ОНЫ 8 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР 36 ДҮГЭЭР ТЭМДЭГЛЭЛ /2017-08-17/</p> <p>ХҮ1.8.2. Нүүрсний экспорттой холбоотой асуудлаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд гарч байгаа саатлыг арилгах талаар хятадын талтай хэлэлцэн шийдвэрлэхийг Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт даалгав</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд Д.Загджав БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Шин Хайминтай 2017 оны 10 дугаар сарын 12-нд уулзаж, Гашуунсухайт-Ганцмод боомт дээр үүсээд буй Тавантолгойн бүлэг ордоос нүүрс тээвэрлэж буй хүнд даацын автомашины түгжрэлийн асуудлыг шуурхай шийдвэрлэх боломжийн талаар санал солилцож, Гаалийн шалгалтын хугацааг богиносгон, боомт дээрх татан авалтын хурдыг нэмэгдүүлэх тал дээр анхаарлаа хандуулж өгөхийг хүссэн ба уг асуудлыг нааштайгаар шийдвэрлэхийн төлөө хичээн ажиллахаа элчин сайд илэрхийлсэн. 2017 оны 11 дүгээр сарын 02-нд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Шин Хайминтай уулзалт хийхдээ Тавантолгойн хэлэлцээрийг үргэлжлүүлж, ажлын хэсгийг байгуулан Хятадын талтай хамтран ажиллах, Гашуунсухайт-Ганцмод боомт дээр үүсээд байгаа нүүрс тээвэрлэж байгаа хүнд даацын автомашины түгжрэлийн асуудлыг шийдвэрлэхэд БНХАУ-ын зүгээс анхаарал тавьж ажиллахыг хүссэн. Монгол Улсын Гадаад хэргийн яам ахалсан Монгол, Хятадын хилийн Ганцмод-Гашуунсухайт боомтод үүссэн нөхцөл байдлыг судлан шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллаж, тухай бүр холбогдох мэдээллийг хүргүүлсэн. Уг ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2018 оны 08 дугаар сарын 28-31-ний өдрүүдэд Улаанбаатар хотод БНХАУ-ын талтай уулзалт хийсэн болно.</p>	<p>100</p> <p>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.</p>	
67	7	7	<p>2018_29. 2018 ОНЫ 7 ДУГААР САРЫН 4-НИЙ ӨДӨР 29 ДҮГЭЭР ТЭМДЭГЛЭЛ /2018-07-04/</p> <p>ХХ.4.2. Байгалийн өнгөт чулууг хууль бусаар олборлох, улсын хилээр гаргахыг хориглох асуудлыг судлах, байгалийн өнгөт чулууны жишиг үнэлгээг тогтоолгохыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт;</p>	<p>Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 131 дүгээр тогтоол, 2014 оны 220 дугаар тогтоол, 2015 оны 102, 103, 488 дугаар тогтоол, 2016 оны 81 дүгээр тогтоолын дагуу уул уурхайн экспортын дараах бүтээгдэхүүнүүдийн олон улсын зах зээлийн үнийг Сангийн сайд болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарын хамтарсан 2018 оны 200/А/177 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нийтэд мэдээлж байгаа болно. Үүнд: Цайр, зэс, цагаан тугалга, хар тугалга, хөнгөн цагаан, молибдени, алт, мөнгө, нүүрс, төмөр, жонш, гянтболдын хүдэр, манганий хүдэр зэрэг багтаж байна. Мөн Уул уурхайн хүнд үйлдвэрийн яамнаас Монгол Улсад үнэт металл, эрдэнийн чулуугаар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түүхий эдээр хангах болон худалдаалах зэрэг асуудлуудыг олон улсын чиг</p>	<p>100</p>	

				хандлагад нийцүүлэх зорилгоор "Үнэт металл, эрдэнийн чулууны үйлдвэрлэл, түүний эргэлтийн тухай" хуулийн төслийг үзэл баримтлалын төслийн хамтаар боловсруулж, үзэл баримтлалын төслийг батлуулахаар Хууль, зүй дотоод хэргийн яаманд 2018 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 01/2026 тоот албан бичгээр хүргүүлсэн.		
68	8	8	<p>2018_35. 2018 ОНЫ 8 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР 35 ДУГААР ТЭМДЭГЛЭЛ /2018-08-22 /</p> <p>XIX.6. "Тавантолгой" ХК нь "Эрдэнэс-Таван толгой" ХК-ийн уурхайн талбайгаас хууль бусаар нүүрс олборлосон эсэх асуудлыг шалгах үүрэг бүхий Ажлын хэсгийн дүнг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав. -Уул уурхайн компаниудын олборлолтын үйл ажиллагаа уулын ажлын төлөвлөгөө, тайлан, нөөцийн хөдөлгөөн болон ТЭЗҮ-ийн дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих, гарсан зөрчил дутагдлыг цаг тухайд нь арилгуулах чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байгаа төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Шадар сайд Ө.Энхтүвшин, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт;</p>	Монгол улсын Ерөнхий сайдын чиглэл болгосны дагуу Сангийн сайдын 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 109 тушаал болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 01/174 тоот удирдамжийн дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Орон нутгийн өмчит "Тавантолгой" ХК нь өөрийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас хил даван "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд нэвтэрч, их хэмжээний нүүрс олборлосон гэх асуудлыг шалгаж, дүгнэлт гаргах, холбогдох арга хэмжээ авах, санал боловсруулах зорилго бүхий Ажлын хэсэг газар дээр нь хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.	30	
69	8	9	XIX.6. "Эрдэнэс-Таван толгой" ХК-ийн уурхайн талбайгаас хууль бусаар олборлосон нүүрсний хэмжээг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар эцэслэн нарийвчлан тогтоолгож, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд шуурхай зохион байгуулж шийдвэрлэх, цаашид компанийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу явуулж, уурхайн олборлолт, экспортын үйл ажиллагаанд хяналт тавьж байхыг	УУХҮСайдын 2018.04.20-ны өдрийн А/86 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг "Тавантолгой" ХК нь "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас нүүрс олборлон ашигласан асуудлыг хянан үзэж, дүгнэлт гаргах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах ажлын хүрээнд 2018.04.19-нөөс 05.06-ны өдрүүдэд дараах үе шаттай ажлуудыг гүйцэтгэн, дүгнэлт, саналыг боловсруулсан. Үүнд: 1. Тусгай зөвшөөрлийн солбилцлын удаа дараагийн өөрчлөлт, хөдөлгөөн нь тусгай зөвшөөрлийн хил давж	100	

			<p>“Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Г.Нандинжаргал)-д, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт;</p> <p>нүүрс олборлосон асуудлын үндсэн үүсэл шалтгаан биш болохыг тогтоосон.</p> <p>2. Хил давж олборлогдсон нөөцийн гурван удаагийн тооцооллын зөрүү 0.3%-3.5% байгаа нь тус хоёр аж ахуй нэгжийн харилцан зөвшөөрсөн нөөцийн тооцоо үнэн зөв байх боломжтой гэж үзэв. (а.“Тавантолгой” ХК болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-иудын хамтарсан ажлын тооцоо; б.Уламжлалт арга буюу блокын аргаар тооцоолсон хяналтын тооцоо; в.Хөндлөнгийн тусгай зөвшөөрөл бүхий маркшейдерийн компаниар хийлгэсэн хэмжилт, хяналтын тооцоо)</p> <p>3.Ажлын хэсгийн томилолтын үед олборлолтонд өртсөн нүүрсний мөргөцөгүүдээс авсан хяналтын дээжлэлт, лабораторийн шинжилгээний үр дүн нь өмнө нь хийгдсэн “Тавантолгой” ХК болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-иудын хамтарсан ажлын хэсгийн тайланд тусгагдсан лабораторийн шинжилгээний үр дүнгүүдтэй ойролцоо үр дүнг илэрхийлж байна.</p> <p>4.Хил давж олборлосон он цагийг нарийвчлан тогтоох ажлыг гүйцэтгэхийн тулд агаар, сансрын зургийг он тус бүрээр гаргуулж, холбогдох суурин боловсруулалтын ажлыг гүйцэтгэх.</p> <p>Мөн Монгол улсын Ерөнхий сайдын чиглэл болгосны дагуу Сангийн сайдын 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 109 тушаал болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 01/174 тоот удирдамжийн дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Орон нутгийн өмчит "Тавантолгой" ХК нь өөрийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас хил даван "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд нэвтэрч, их хэмжээний нүүрс олборлосон гэх асуудлыг шалгаж, дүгнэлт гаргах, холбогдох арга хэмжээ авах, санал боловсруулах зорилго бүхий Ажлын хэсэг газар дээр нь хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтаар “Тавантолгой” ХК нь уурхайн 4 дүгээр амны зүүн, зүүн хойд хэсэгт IVa давхаргын таазнаас олборлолт явуулсан, 4 дүгээр амны хойд хэсэгт IVa давхаргын таазнаас олборлолт явуулсан, 4 дүгээр амны зүүн хойд</p>		
--	--	--	---	--	--

			<p>хэсэгт IVб давхаргын хэсэгт олборлолт явуулсан, 4 дүгээр амны баруун хэсэгт IVa давхаргын хэсгүүдээр зааглагдан нийт таван хэсэгт 340,092.98 тонн нүүрс “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайгаас олборлосныг мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллага “Хос Алтан Пирамид” ХХК-ийн хийсэн маркшейдерийн хэмжилтээр тогтоосон байна. “Эрдэнэс-Тавантолгой” ХК нь өөрийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дахь уурхайн талбайн аюулгүй байдал, шав тэмдгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалаагүйгээс орон нутгийн өмчит “Тавантолгой” ХК-ийн ашиглалтын MV-016882, MV-011943 тоот тусгай зөвшөөрлийн хилийг даван нүүрс олборлох үйл ажиллагаа эхлэхэд таслан зогсоох арга хэмжээ авч ажиллаагүй нь хууль бусаар нүүрс олборлох нөхцөлийг бүрдүүлсэн байна гэж Ажлын хэсэг дүгнэсэн. Авлигатай тэмцэх газрын 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр 09/236 тоот албан бичгээр “Тавантолгой” ХК, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хамтарсан баг 2015, 2016 онуудад 3 удаагийн хэмжилт хийж, “Тавантолгой” ХК нь “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайгаас 268.3 мян.тн нүүрс олборлосон, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны а/86 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг “Их нэмүүн” ХХК-аар хэмжилт хийлгэхэд “Тавантолгой” ХК нь “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайгаас 267.68 мян.тн нүүрс олборлосон, МХЕГ-ын даргын 2018 оны 01/174 тоот удирдамжаар батлагдсан Ажлын хэсэг “Хос Алтан Пирамид” ХХК-аар хэмжилт хийлгэхэд “Тавантолгой” ХК нь “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайгаас 340,09298 тонн нүүрс олборлосон тухай зөрүүтэй 3 тайланг гарсан байгааг буруушаасан. Дээрх зөрүүтэй байдлаас үүдэн хөндлөнгийн маркшейдерийн байгууллагаар хэмжилт хийлгэн нэгдсэн үнэн зөв үндэслэл бүхий тооцоололтой дүгнэлт, тайлан гаргуулах тухай албан хүсэлтийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт ирүүлсэн байна. Уг хүсэлтийн дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 29-ний А/21 дугаар тушаалаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Монголын Маркшейдерийн холбоо,</p>		
--	--	--	--	--	--

				<p>“Тавантолгой” ХК, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн төлөөллийг оролцуулсан хөндлөнгийн геологи, маркшейдерийн хэмжилт хийлгэн нэгдсэн үнэн зөв үндэслэл бүхий тооцоололтой дүгнэлт, тайлан гаргуулах үүрэг бүхий Ажлын хэсэг болон дүгнэлт, тайлан гаргах үүрэг бүхий геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах Ажлын хэсгийг тус тус байгуулан ажилласан. Хөндлөнгийн тайлан гаргуулах үүрэг бүхий ажлын хэсэг маркшейдерийн хяналтын хэмжилт хийх байгууллагыг сонгон шалгаруулах ажлын даалгаврыг боловсруулан сонгон шалгаруулах Ажлын хэсэгт хүргүүлснээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд Тендерийн бичиг баримтыг боловсруулан 2019 оны 03 дугаар сарын 04-ний өдөр цахим тендер зарласан бөгөөд 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр 11:30 цагт нээхэд аж ахуйн нэгжүүдээс тухайн тендерт оролцох санал ирүүлээгүй тул дахин 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 2019 оны 04 дүгээр сарын 02-ны хооронд 7 хоногийн хугацаатай зарласан боловч мөн тухайн тендерт оролцох саналыг ирүүлээгүй болно. Иймд хөндлөнгийн маркшейдерийн хяналтын хэмжилтийг гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулах боломжгүй болсон тул Ажлын хэсгээс хуульд заасан холбогдох арга хэмжээг авч ажиллах талаар Авлигатай тэмцэх газарт 2019 оны 04 дүгээр сарын 10-ны 03/1236 дугаар албан бичгийг хүргүүлэн ажилласан болно.</p>		
70	9	10	<p>2018_49. 2018 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР 49 ДҮГЭЭР ТЭМДЭГЛЭЛ /2018-11-28/</p> <p>2.2. нүүрсний ачилт, тээвэрлэлтийг авто замын даац, техникийн бүрэн байдал, аюулгүй ажиллагааг хангасан автотээврийн хэрэгслийн тоо, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим, аж ахуйн нэгж тус бүрийн нүүрс олборлолтын хэмжээ, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадалтай уялдуулан зохион байгуулж, нүүрс тээвэрлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд</p>	<p>Засгийн газрын тэмдэглэлийн дагуу тус яамнаас Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ болон холбогдох төрийн байгууллагуудад хилээр нэвтрэх олон улсын С зөвшөөрлийг замын даац, техникийн бүрэн бүтэн байдал, уурхайн олборлолтын хэмжээтэй уялдуулж олгох тухай чиглэлийг улирал бүр тогтоож өгч байна. Энэхүү ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаас 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн 01/20, 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/774 тоот албан бичгүүдийг Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ болон бусад холбогдох төрийн байгууллагуудад тус тус хүргүүлсэн.</p>	70	

			Д.Сумъяабазар, Зам, тээврийн хөгжлийн сайд Я.Содбаатар, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт нарт;			
71	9	11	2.3. нүүрс худалдах, худалдан авах талаар хоёр улсын аж ахуйн нэгж хооронд байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах, шаардлагатай бол нүүрсийг урт хугацаанд тогтвортой худалдах чиглэлээр гэрээг шинэчлэх болон хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудлаар Хятадын талтай яриа хэлэлцээ хийхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт;	Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд Д.Загджав БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Шин Хайминтай 2017 оны 10 дугаар сарын 12-нд уулзаж, Гашуунсухайт-Ганцмод боомт дээр үүсээд буй Тавантолгойн бүлэг ордоос нүүрс тээвэрлэж буй хүнд даацын автомашины түгжрэлийн асуудлыг шуурхай шийдвэрлэх боломжийн талаар санал солилцож, Гаалийн шалгалтын хугацааг богиносгон, боомт дээрх татан авалтын хурдыг нэмэгдүүлэх тал дээр анхаарлаа хандуулж өгөхийг хүссэн ба уг асуудлыг нааштайгаар шийдвэрлэхийн төлөө хичээн ажиллахаа элчин сайд илэрхийлсэн. 2017 оны 11 дүгээр сарын 02-нд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Шин Хайминтай уулзалт хийхдээ Тавантолгойн хэлэлцээрийг үргэлжлүүлж, ажлын хэсгийг байгуулан Хятадын талтай хамтран ажиллах, Гашуунсухайт-Ганцмод боомт дээр үүсээд байгаа нүүрс тээвэрлэж байгаа хүнд даацын автомашины түгжрэлийн асуудлыг шийдвэрлэхэд БНХАУ-ын зүгээс анхаарал тавьж ажиллахыг хүссэн. Монгол Улсын Гадаад хэргийн яам ахалсан Монгол, Хятадын хилийн Ганцмод-Гашуунсухайт боомтод үүссэн нөхцөл байдлыг судлан шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллаж, тухай бүр холбогдох мэдээллийг хүргүүлсэн. Уг ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2018 оны 08 дугаар сарын 28-31-ний өдрүүдэд Улаанбаатар хотод БНХАУ-ын талтай уулзалт хийсэн болно.	100	
72	9	12	2.4. уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх төмөр зам, авто зам барьж байгуулах ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Я.Содбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт;	Тус яамнаас Тавантолгой-Зүүнбаян, чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төсөлд 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 01/1683, 01/1689 тоот албан бичгээр санал өгч ажилласан болно.	100	Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.
73	9	13	2.6. нүүрс тээвэрлэж байгаа жолооч нарыг эрүүл мэндийн нэг удаагийн үзлэгт хамруулах ажлыг ойрын хугацаанд зохион	Нүүрс тээврийн жолооч нарыг эрүүл мэндийн үзлэг оруулах ажлыг Эрүүл мэндийн яамнаас ахлан зохион байгуулсан. Уг ажилд зарцуулагдах хөрөнгийг “Эрдэнэс	100	

			байгуулахыг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал П.Ганхүү, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захирал П.Дэлгэрнараран нарт;	Монгол” ХХК болон “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ нар хамтран гаргасан болно.	Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.	
74	10	14	2018_51. 2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДӨР 51 ДҮГЭЭР ТЭМДЭГЛЭЛ /2018-12-12/ II.2. “Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх Ажлын хэсгийг холбогдох яам, агентлагийн төлөөлөлтэй байгуулан ажиллуулж, хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн нь тогтоогдсон хуулийн этгээдээр нөхөн сэргээлт хийлгэх, тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авч, дүнг 2019 оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү нарт даалгав.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/51 дугаар тушаалаар батлагдсан Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх ажлын хэсгийн байнгын удирдамжийн хүрээнд 2019 оны 3 дугаар сард нөөц дууссан, нөөцгүй эсхүл нөөц нь тодорхойгүй ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийн байдалд, мөн тус тушаалын хүрээнд 2019 оны 5 дугаар сард Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст ажиллаж, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн байдалд шалгалтыг хийж гүйцэтгэн удирдлагад танилцуулсан.	100	
75	10	15	II.3. Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Бадрах Энержи” ХХК-ийн “Зөөвч-Овоо” туршилтын үйлдвэрийн түр зориулалтын барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссыг 2018 оны 12 дугаар сард багтаан томилж ажиллуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав.	Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэлийн 3 дахь хэсэгт “Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй “Бадрах энержи” ХХК-ийн Зөөвч овоо төслийн технологийн туршилтын үйлдвэр, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг 2018 оны 12 дугаар сард багтаан томилон ажиллуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав.” хэмээн чиглэл өгсөний дагуу хоёр сайдын хамтарсан 2019 оны А/18/16 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулан туршилтын үйлдвэрийн барилга байгууламж, бичиг баримтуудтай танилцаж, холбогдох зөвлөмж, дүгнэлтийг ажлын хэсгийн гишүүдийн олонхийн саналаар гаргасан болно.	70	
76	11	16	2019_6. 2019 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР 6 ДУГААР ТЭМДЭГЛЭЛ	“Эрдэнэс-Тавантолгой” ХК байгуулагдсан цагаас хойш нийтдээ 192.2 сая м3 хөрс хуулалтын ажил гүйцэтгэж,	100	

			<p align="center">/ 2019-01-30 /</p> <p>XXII.5. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг энэ оны эхний улиралд багтаан холбогдох хууль тогтоомжийн дагуу судалж шийдвэрлэхийг тус компанийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгав.</p>	<p>нийт 45.92 сая тонн нүүрс олборлосон бөгөөд үүнээс 2018 онд нийт 11.0 сая тонн нүүрс олборлож, 13.1 сая тонн нүүрс борлуулсан байна. Ийнхүү үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдсэнээр 2018 оны аудитлагдаагүй тайлангаар борлуулалтын орлогын хэмжээ 1,986.9 тэрбум төгрөгт, улсын төсөвт татвар, хураамж хэлбэрээр нийт 484.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, татварын дараах цэвэр ашиг 801.1 тэрбум төгрөгт хүрсэн. Дээрх үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал борлуулалтын орлогын хэмжээ 804.5 тэрбум буюу 68 хувиар, цэвэр ашгийн хэмжээ 340 тэрбум төгрөг буюу 74 хувиар тус тус өссөн байна. Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8 дах хэсэгт “Ногдол ашгийг компанийн татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилна” гэж, Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 210 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ын 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтад “Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг нийтэд мэдээлэх ёстой бөгөөд уг мэдээлэл нь ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн ойлголт өгөхүйц байх ёстой.” гэж тус тус тусгагдсан байхын зэрэгцээ тус кодекст “Компанийн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний хуваарилалтыг хасаад үлдэх хэсгийг ногдол ашигт хуваарилж байх нь зүйтэй” гэж тайлбарласан байдаг. Энэ хүрээнд “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар ногдол ашиг хуваарилах асуудлыг хэлэлцээд нэгж хувьцаанд 25 төгрөгийн ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 03 дугаар тогтоолыг баталсан болно.</p>		
77	12	17	<p>2019_8. 2019 ОНЫ 2 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР 8 ДУГААР ТЭМДЭГЛЭЛ /2019-02-08 /</p> <p>XIII.6. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам, авто замын төслүүдийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. “Тавантолгой-</p>	<p>Тус яам болон Зам, тээврийн хөгжлийн яамнаас Засгийн газрын тэмдэглэлийн дагуу төмөр замын төслүүдийг эрчимжүүлэх тухай танилцуулга, шийдвэрийн төслүүдийг боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулсан болно. Үүний үр дүнд Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 135 дугаар тогтоол, 2019 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 189 дүгээр тогтоолууд тус тус батлагдан гарсан болно.</p>	100	

			Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын 2018 оны 242 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, хэрэгжилтийн явцыг 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав.			
78	12	18	XIII.7. . “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2018 оны санхүүгийн жилийн ногдол ашиг хуваарилах асуудлыг Засгийн газрын гишүүдийн саналыг авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав.	Засгийн газрын тэмдэглэлийн дагуу Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 16 дугаар хуралдаанд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2018 оны санхүүгийн жилийн ногдол ашиг хуваарилах асуудлыг танилцуулж, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хурлаар ногдол ашиг хуваарилах асуудлыг авч хэлэлцээд өмнө гаргасан тогтоолыг хүчингүй болгохоор шийдвэрлүүлсэн.	70	
79	13	19	2019_9. 2019 ОНЫ 2 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР 9 ДУГААР ТЭМДЭГЛЭЛ /2019-02-27/ ХҮ.1. . “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааны талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Эрдэнэс Монгол” ХХК-ийн талаар цаашид авах арга хэмжээний талаар тодорхой санал боловсруулан зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд, стратегийн орд газруудын нөхцөл байдлын талаар Засгийн газрын дараагийн хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт тус тус даалгав.	Засгийн газрын 2019.06.12-ны өдрийн хуралдаанд Салхитын мөнгөний орд болон Багануурын хүрэн нүүрсний ордуудын өнөөгийн нөхцөл байдлын талаар УУХҮС Д.Сумъяабазар засгийн газрын гишүүдэд танилцуулсан. Үүнтэй холбогдуулан Салхит болон Багануурын ордод хамаарах цуцлагдсан ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлүүдийн талбайд төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээр дамжуулан ашигт малтмал эрэх, хайх, ашиглах зорилгоор тухайн талбайнуудын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхээр Д.Сумъяабазарт даалгасны дагуу АМГТГ-ын даргад арга хэмжээ авах тухай албан бичгийг 2019.06.26 өдрийн 01/1929 дугаар бичгээр хүргүүлсэн.	100	

80	14	20	<p>2019_16. 2019 ОНЫ 4 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР 16 ДУГААР ТЭМДЭГЛЭЛ /2019-04-10/</p> <p>III.. 1. Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 6, мөн оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 8 дугаар тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2018 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах талаар гаргасан тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолыг хүчингүй болгох арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (М.Баяраа)-д даалгав.</p>	Засгийн газрын шийдвэрийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан болно.	30	
Хэсгийн дундаж: 79.1%						
САЛБАР ЧИГЛЭЛ: 4. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГО						
4.а. Монгол Улсын хууль						
81	1	1	<p>ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ /2015-07-09/</p> <p>6.1.1. "6 дугаар зүйл Засгийн газрын бүрэн эрх 6.1.1. Үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангах;"</p>	Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 29-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор "Хүнд аж үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийг боловсруулж хэлэлцүүлэн батлуулсан. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар батлуулахаар ажиллаж байна.	100	
82	2	2	<p>ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ /2017-05-12/</p> <p>8.6.2. 8.6. Хог хаягдлын талаар уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.6.2. Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам баталж, хэрэгжилтэд хяналт тавих;</p>	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/35 тушаалаар “Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам”-ын төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг 2019.02.19-ны өдөр байгуулсан бөгөөд ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд журмын төслийн анхны хувилбарыг Уул уурхайн хэлтэс, Газрын тосны хэлтсийн холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулан ажиллаж байна. Мөн журмын төсөл боловсруулахтай холбогдуулан 21 аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрууд болон нэр бүхий 26 уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарт үйл ажиллагаа эрхлэгч ААНБ-уудаас шаардлагатай мэдээлэл ирүүлэх тухай албан бичиг хүргүүлсний дагуу 2019.05.31-ний өдрийн	70	

				байдлаар 14 аймаг, 14 ААНБ-аас холбогдох мэдээллийг ирүүлээд байна.		
<i>4.б. УИХ-ын тогтоол</i>						
83	1	1	2015_36. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ЧИГЛЭЛ ӨГӨХ ТУХАЙ /2015-02-17/ 10. 10/цахилгаан эрчим хүч, ган, нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэж, экспортлох асуудлаар нэгдсэн бодлого боловсруулж 2015 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах;	УИХ-ын 2015 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 36 дугаар тогтоолын 1 дэх заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн төслийг боловсруулан УИХ-ын 2015 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн 62 дугаар тогтоолоор батлуулсан. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн "4.2.3.6.газрын тос, нүүрс хими, кокс хими, өнгөт болон хар төмөрлөгийн үйлдвэрийг дагалдах үйлдвэрийн хамт цогцоор нь байгуулах"-аар заасан.	100	Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн, Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг батлуулсан тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.
84	1	2	11. 11/энэ тогтоолын 1 дэх заалтын 10 дахь дэд заалтад заасан нэгдсэн бодлогын агуулгад нийцсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах.	МУ-ын ЗГ-ын 2016.09.28-ны өдрийн 107 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд УУХҮС-ын 2016 оны А/43 дугаар тушаалаар УУХҮЯ-ны дэргэд "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих" төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулан ажиллаж байна. Төслийн НТЭЗҮ-г 2017.5-р сард, БНБОУ-ний тайланг 2019.2-р сард хүлээн авсан бөгөөд олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг 2019.2.19-нөөс 25-ны өдрүүдэд Нийслэлийн 4 дүүрэг, Төв аймгийн 6 суманд амжилттай зохион байгуулсан. ДБ-ны стандарт, шаардлагад нийцсэн БОННБНҮ-ний эцсийн тайланг 2019 оны эхний хагаст хүлээн авна. Төслийн ТЭЗҮ-д тооцоолсон одоогийн хүчин чадлаар үйлдвэрийг барихад 2.5 тэрбум ам.доллар буюу их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа нь төслийн санхүүжилтийг босгоход хүндрэл учруулж байна. Иймд төслийг үе шаттайгаар хэрэгжүүлж зорилтот хүчин чадалд хүргэх боломжийг судлах зорилгоор батлагдсан ТЭЗҮ-д нэмэлт тодотгол хийхээр СЯ болон УУХОДТ-тэй зөвшилцөж байна. Цаашид төслийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх бизнесийн хэлцэл хийхэд ТН-г бие даасан ААН болгон өөрчлөн зохион байгуулах шаардлагатай байгаа тул тус асуудлыг УУХҮС-ын зөвлөлийн 2019.1.30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд тус асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх тухай 02 тоот шийдвэрийг гаргасан. Дээрх шийдвэрийн хэрэгжилтийг	30	

				хангах ажлын хүрээнд ННБХҮҮБ төслийн нэгжийг бие даасан төрийн өмчит компани хэлбэрээр зохион байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан УУХҮС-ын 2019.3.28-ны өдрийн 01/831 тоот албан бичгээр бүх яамдаас санал авч нэгтгэн, ЗГ-н хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтоолын төслийг яамдын саналын товъёогийн хамт УУХҮ-ийн сайдын 2019.5.02-ны 01/1267 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. ЗГХЭГ-ын даргын 2019.5.16-ны өдрийн ХЭГ/1381 тоот албан бичгээр ирүүлсний дагуу ЗГ-ын тогтоолын төсөлд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн саналыг авч УУХҮС-ын 2019.6. 05-ны 01/1679 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлээд байна.		
<i>4.в. УИХ-ын Байнгын хорооны тогтоол</i>						
<i>4.г. Ерөнхийлөгчийн зарлиг</i>						
<i>4.д. ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл</i>						
<i>4.е. Засгийн газрын тогтоол</i>						
85	1	1	<p>2017_88. ЗЭСИЙН БАЯЖМАЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ /2017-03-15 /</p> <p>2. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулж хамтран ажиллах хөрөнгө оруулагчийг сонгох, хөрөнгө оруулагчтай байгуулах гэрээний талаар хэлцэл хийх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулан ажлын явц, үр дүнг Засгийн газарт тухай бүр танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан нарт даалгасугай.</p>	Хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах ажлын хэсгийн дагаж мөрдөх журам, хөрөнгө оруулагчид тавигдах шаардлага, Хөрөнгө оруулагчын гэрээний төсөл боловсруулах ажлыг тус төслийн хуулийн зөвлөх компани /"Таван Лекс" ХХН/ нь гэрээний дагуу гүйцэтгэн тайланг хүлээлгэн өгсөн. Мөн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, уг төслийг хэрэгжүүлэгч нэгжид дэмжлэг үзүүлэх зорилгоор төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулахад хууль, санхүүгийн гадаад, дотоодын зөвлөхийг сонгон шалгаруулах тендерт шалгарсан Өмгөөллийн “Монгол Өмгөөлөгч” ХХН-тэй гэрээ байгуулж, хөрөнгө оруулагчтай байгуулах гэрээний төсөл, эрх зүйн баримт бичиг, холбогдох тайланг хүлээн авсан. Үүний дагуу Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах журмыг олон улсын жишиг аргачлалын дагуу боловсруулж, Сангийн сайд, Уул уурхай, хүнд	30	

				<p>үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалаар батлуулахаар ажиллаж байна. Улмаар хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулсны дараа "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр"-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн хувийг хөрөнгө оруулагчтай эцэслэн тохиролцох юм. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг байгуулах тухай асуудлыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлж, зөвлөмж гарсан бөгөөд Засгийн газрын 2019.05.17-ны өдрийн "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" 196 дугаар тогтоолоор Засгийн газрын 2017.9.13-ны өдрийн 247 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-д хамруулж нэн чухал асуудлаар анхааран ажиллаж байна.</p>		
86	1	2	<p>3. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр үнэ төлбөргүй эзэмших асуудлыг зөвшөөрч, төрийн төлөөллийг зохих журмын дагуу хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт даалгасугай.</p>	<p>УУХҮСайдын 2016 оны А/71 тоот тушаалаар "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр"-ийн төслийн нэгжийг өөрчлөн зохион байгуулж ажиллаж байна. УУХҮЯ-ны дэргэдэх "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл" хэрэгжүүлэх нэгж Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан УУХҮЯ-ны дэргэдэх "Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөл"-өөр 2018.08.14-ний өдөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулсан. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн Байгаль орчны ерөнхий үнэлгээний тайланг мэргэжлийн байгууллагаар хийлгэн 2018.05.20-нд хүлээн авсан бөгөөд уг тайланг БОАЖЯ хянан үзэж 2018.11.27-ны өдрийн 13/8361 дугаартай албан бичгээр дүгнэлт гаргаж ирүүлсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны төсвийн багцад Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах зардлыг тусгуулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019.01.21-ний өдрийн "Тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай" А/16 дугаар тушаалаар Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдан ажиллаж байна. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих зорилгоор Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт орших 466 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх зориулалтаар Засгийн газрын 2018.12.12-ны өдрийн</p>	/-/	

				“Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” 378 дугаар тогтоол гаргуулсан. Тус тогтоолын дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга болон Өмнөговь аймгийн засаг даргатай 2019.04.10-ны өдөр Улсын тусгай хэрэгцээний газрыг ашиглах 2019/16 дугаар гэрээг байгуулсан.		
87	2	3	<p>2017_232. ХЭРЛЭН ГОЛ ДЭЭР УРСАЦЫН ТОХИРУУЛГА ХИЙХ ТӨСЛИЙН ТУХАЙ /2017-08-17/</p> <p>1.. Өмнийн говьд байгуулагдах томоохон бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, дэд бүтцийн болон бусад төслүүдийн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх “Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төсөл”-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт даалгасугай.</p>	<p>“Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төсөл”-ийн техник эдийн засгийн үндэслэл болон байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлүүлэх асуудлаар 2017 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр “Хүсэлт хүргүүлэх тухай” 01/2020 тоот албан тоотыг Сангийн яаманд хүргүүлсэн. Уг төслийг хэрэгжүүлэх, тендер шалгаруулалтыг 2018 онд зохион байгуулах ажлын үндсэн хариуцагчаар БОАЖЯ ажиллаж байгаа болно. Өмнийн говьд байгуулагдах томоохон бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, дэд бүтцийн болон бусад төслүүдийн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төслийн усан хангамжийг шийдвэрлэх боломжит хувилбарыг тодорхойлж, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд төсөлд шаардлагатай ус ашиглах зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгох хүсэлтийг 2019.02 дугаар сард хүргүүлсний дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаас Дорноговь аймгийн Мандах сумын нутагт байрлах Цагаан цавын газрын доорх усны ордоос үйлдвэрлэлийн С1 зэргээр үнэлсэн 800 л/с нөөцөөс дээрх төсөлд шаардлагатай 220 л/с усны хэрэглээг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх боломжтой талаар хариуг 2019.03.26-ны өдрийн 01/1787 дугаар албан бичгээр ирүүлсэн. Мөн Дорноговь аймгийн Алтан ширээ сумын нутагт орших Бор хөөврийн говийн газрын доорх усны ордоос “Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах” төсөлд шаардлагатай усыг хангах асуудлаар санал боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, ЗГ-ын 2019.05.12-ны өдрийн 21 дүгээр тэмдэглэл гаргасан. Энэхүү тэмдэглэлд дээрх асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр яаралтай хэлэлцүүлэх шийдвэр гарсан. Дээрх шийдвэрийн дагуу ЗГХЭГ-аас 2019.05.21-ний өдөр ҮАБЗ-өөр газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай</p>	70	

				усан хангамжийн асуудлыг хэлэлцүүлэхээр албан бичиг хүргүүлээд байна.		
88	3	4	<p>2018_323. ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР БАРИХ ТӨСЛИЙН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ /2018-10-24 /</p> <p>3. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий тосоор найдвартай хангах асуудлаар холбогдох байгууллага, компанитай уулзалт, хэлэлцээр хийж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн нарт үүрэг болгосугай.</p>	Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдах газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий тосоор хангах асуудлын хүрээнд АМГТГ-аас ажлын хэсэг байгуулан газрын тосны ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа “Петрочайна Дачин Тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-тай 2 удаагийн уулзалт зохион байгуулж, уг асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна.	70	
89	3	5	4. Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий тос дамжуулах хоолойн техник, технологийн шийдлийг сонгох, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх талаар санал боловсруулж танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай.	Түүхий тос дамжуулах хоолойг нарийвчилсан ТЭЗҮ-ээр тооцоолсон хөрөнгө оруулалтын зардлаас бага өртөгтэйгээр Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хэрэглэгдэж байгаа уламжлалт технологийг ашиглан байгуулах санхүүжилтийн болон техникийн боломжийг шийдвэрлэхэд Засгийн газрын баталгаа зайлшгүй шаардлагатай байгаа тул Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн зүгээс түүхий тос дамжуулах хоолойн асуудлыг Засгийн газар болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулахаар бэлтгэж байна.	70	
90	3	6	5.Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн менежментийн зөвлөх компанийг сонгон шалгаруулах ажлыг эрчимжүүлж, төслийн үе шатны ажлуудыг шуурхай зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай.	Үйлдвэрийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл бэлэн болсонтой холбогдуулан төслийн менежментийн зөвлөх компанийг хоёр улсын хооронд байгуулсан 1.0 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрт заасны дагуу сонгон шалгаруулсан бөгөөд Энэтхэг Улсын Засгийн газрын зүгээс тус улсын төрийн өмчит “Инженерс Индиа Лимитед” компанийг төслийн зөвлөхөөр сонгосон. Төслийн менежментийн зөвлөх компаниар шалгарсан Энэтхэгийн “Инженерс Индиа Лимитэд” төрийн өмчит компани болон “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК нар зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг 2019.05.13-ны өдөр байгуулсан. Ингэснээр үйлдвэрийн инженер техникийн зураг төсөл,	100	

				бүтээн байгуулалтын ажлууд эхлэхэд бэлэн болоод байна.		
91	3	7	6. Үйлдвэрийн байршил хүртэлх дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явц, гүйцэтгэл, зээлийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т, төсөл хэрэгжүүлэгч компанийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт тус тус даалгасугай.	Засгийн газрын 2018.01.03-ны өдрийн “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолоор боловсруулах үйлдвэрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Монгол Улсын Хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлж, төмөр зам, автозам, цахилгаан дамжуулах агаарын шугам, үйлдвэрийн талбайн газар шорооны ажлуудыг 2018 оны эхний хагас жилд багтаан эхлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Зам, тээвэр хөгжлийн сайд, Эрчим хүчний сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан. Үйлдвэр байгуулахад шаардлагатай гаднах дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд болох “Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр” чиглэлийн 27 км урт салаа төмөр зам, 18.2 км, 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/10 кВ-ын 6.3 МВ-ын суурилагдсан хүчин чадал бүхий дэд станц болон 16.63 км урт хатуу хучилттай автозам барих төслүүдийн барилга угсралтын ажлыг 2018.06.22-ны өдөр Дорноговь аймгийн Алтанширээ суманд эхлүүлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар барилга угсралтын ажлын явц 90 гаруй хувийн гүйцэтгэлтэй байна. Дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлуудыг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ашиглалтад хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад зориулан "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК болон Монгол Улсын Хөгжлийн банк хооронд ирээдүйд бий болох хөрөнгийг барьцаалан буцаан төлөх нөхцөлтэйгөөр 2018.04.13-ны өдрийн БГ-МГТ-ИХ 2018-44 дугаар "Барьцааны гэрээ" болон мөн өдрийн ЗГ-МГТ-З 2018-43 дугаар "Зээлийн гэрээ"-г тус тус байгуулсан. Энэхүү зээлийн хөрөнгөөр "Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр" чиглэлийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэлийн дагуу үе шаттайгаар санхүүжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2019 оны 06 дугаар сарын байдлаар уг төсөлд "Хөгжлийн банк"-наас нийт 120 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.	100	

92	4	8	<p align="center">2019_129. ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР БАРИХ ТӨСЛИЙН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ /2019-04-03/</p> <p>1.. Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн хүрээнд үйлдвэрийн ажилчдыг орон сууцаар хангах зорилгоор Дорноговь аймгийн Сайншанд хотын нутаг дэвсгэрт барих 550 айлын орон сууцны хотхоны бүтээн байгуулалтын ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг нарт даалгасугай.</p>	<p>Тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ажилчдын хотхоны бүтээн байгуулалтад шаардагдах импортоор оруулж ирэх бараа материал, тоног төхөөрөмжийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, гаалийн албан татварыг чөлөөлж, буцаан олгох тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулан санал авахаар 2019.05.08-ны өдрийн 01/1357 дугаар албан бичгээр Сангийн сайд болон Хууль, зүй дотоод хэргийн сайдад хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019.05.22-ны өдрийн 1-1/2352 дугаар албан бичиг, Сангийн сайдын 2019.05.27-ний өдрийн 4-2/3417 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус тусган нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай болон гаалийн албан татварыг буцаан олгох тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу дахин хүргүүлээд байна. ЗГ-ын 2019.06.05-ны өдрийн 25 дугаар тэмдэглэл гарч Дорноговь аймгийн Сайншанд суманд байгуулах ажилчдын хотхоны барилгын зураг төслийг хэсэгчлэн батлуулах, туслан гүйцэтгэгч байгууллагыг сонгон гэрээ байгуулж, хотхоны бүтээн байгуулалтын ажлыг шуурхай эхлүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Батлан хамгаалахын сайд, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал нарт даалгасан. ЗГ-аас өгсөн чиглэлийн дагуу барилгын зураг төсөл болон барилга угсралтын ажлыг гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулсан бөгөөд зураг төслийн ажлыг 2019 оны 6 дугаар сард багтаан хэсэгчлэн батлуулж, батлагдсан зураг төслийн дагуу хотхоны барилга угсралтын ажлыг 7 дугаар сард эхүүлэхээр ажиллаж байна.</p>	30	
93	4	9	<p>2.. Хотхоны бүтээн байгуулалтад шаардагдах бараа материал, тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулж 2019 оны 5 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай.</p>	<p>Тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ажилчдын хотхоны бүтээн байгуулалтад шаардагдах импортоор оруулж ирэх бараа материал, тоног төхөөрөмжийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, гаалийн албан татварыг чөлөөлж, буцаан олгох тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулан санал авахаар 2019.05.08-ны өдрийн 01/1357 дугаар албан бичгээр Сангийн сайд болон Хууль, зүй дотоод хэргийн сайдад</p>	30	

				хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019.05.22-ны өдрийн 1-1/2352 дугаар албан бичиг, Сангийн сайдын 2019.05.27-ний өдрийн 4-2/3417 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус тусган нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай болон гаалийн албан татварыг буцаан олгох тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу дахин хүргүүлээд байна. ЗГ-ын 2019.06.05-ны өдрийн 25 дугаар тэмдэглэл гарч Дорноговь аймгийн Сайншанд суманд байгуулах ажилчдын хотхоны барилгын зураг төслийг хэсэгчлэн батлуулах, туслан гүйцэтгэгч байгууллагыг сонгон гэрээ байгуулж, хотхоны бүтээн байгуулалтын ажлыг шуурхай эхлүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Батлан хамгаалахын сайд, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал нарт даалгасан. ЗГ-аас өгсөн чиглэлийн дагуу барилгын зураг төсөл болон барилга угсралтын ажлыг гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулсан бөгөөд зураг төслийн ажлыг 2019 оны 6 дугаар сард багтаан хэсэгчлэн батлуулж, батлагдсан зураг төслийн дагуу хотхоны барилга угсралтын ажлыг 7 дугаар сард эхүүлэхээр ажиллаж байна.		
94	4	10	4.. Хотхоны бүтээн байгуулалтын ажлыг 2019 оны эхний хагас жилд багтаан эхлүүлж, ажлын явц, үр дүнгийн талаар Засгийн газарт улирал тутам танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, орон нутгийн зүгээс шаардлагатай дэмжлэг үзүүлэхийг Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин нарт тус тус даалгасугай.	Тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ажилчдын хотхоны бүтээн байгуулалтад шаардагдах импортоор оруулж ирэх бараа материал, тоног төхөөрөмжийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, гаалийн албан татварыг чөлөөлж, буцаан олгох тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулан санал авахаар 2019.05.08-ны өдрийн 01/1357 дугаар албан бичгээр Сангийн сайд болон Хууль, зүй дотоод хэргийн сайдад хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019.05.22-ны өдрийн 1-1/2352 дугаар албан бичиг, Сангийн сайдын 2019.05.27-ний өдрийн 4-2/3417 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус тусган нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай болон гаалийн албан татварыг буцаан олгох тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу дахин хүргүүлээд байна. ЗГ-ын 2019.06.05-ны өдрийн 25	30	

				<p>дугаар тэмдэглэл гарч Дорноговь аймгийн Сайншанд суманд байгуулах ажилчдын хотхоны барилгын зураг төслийг хэсэгчлэн батлуулах, туслан гүйцэтгэгч байгууллагыг сонгон гэрээ байгуулж, хотхоны бүтээн байгуулалтын ажлыг шуурхай эхлүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Батлан хамгаалахын сайд, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал нарт даалгасан. ЗГ-аас өгсөн чиглэлийн дагуу барилгын зураг төсөл болон барилга угсралтын ажлыг гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулсан бөгөөд зураг төслийн ажлыг 2019 оны 6 дугаар сард багтаан хэсэгчлэн батлуулж, батлагдсан зураг төслийн дагуу хотхоны барилга угсралтын ажлыг 7 дугаар сард эхүүлэхээр ажиллаж байна.</p>		
				<i>4.ё. Ерөнхий сайдын захирамж</i>		
95	1	1	<p>2016_113. АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАХ ТУХАЙ” НҮҮРСНЭЭС НИЙЛЭГ БАЙГАЛИЙН ХИЙ ҮЙЛДВЭРЛЭХ ҮЙЛДВЭР” БАРЬЖ БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ТАЛААР ХЭЛЭЛЦЭЭ ХИЙЖ, САНАЛ, ДҮГНЭЛТ БОЛОВСРУУЛАХ / 2016-11-22 /</p> <p>2. Ажлын хэсгийн баримтлан ажиллах удирдамжийг хавсралт ёсоор баталж, төслийн хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийж санал, дүгнэлт боловсруулан, дүнг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Дашдорж)-т даалгасугай.</p>	<p>Тус ажлын хэсгийн хурал 2017 оны 01 дүгээр сарын 25 өдөр хуралдаж дараах шийдвэр гарсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.ЭХЯамны түгээх шугам сүлжээний журам, стандартаа гаргах ажлын хэсэгт ХҮБГ-аас мэргэжилтэн ажиллуулах 2.БОАЖЯ, ННБХҮ үйлдвэрийн төслийн ТЭЗҮ-ний хүрээнд хийгдсэн БОННҮ-нд холбогдолтой дүгнэлтийг гаргах; 3.Төслийн нэгж, Эрдэнэс Монгол ХХК болон Багануурын уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх, судалгаа хийх, холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах, Багануурын уурхайн удирдлага мэргэжилтнүүдэд төслийг танилцуулах; 4.Төслийн нэгж, Төв аймгийн Баяндэлгэр суманд төслийн байршлын газрын асуудлаар 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор аймгийн удирдлагуудтай хамтран ажиллах. <p>Дээрхи шийдвэрийн дагуу дараах ажлууд хийгдсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Эрчим хүчний сайдын 2017 оны 03 сарын 15-ны өдрийн 36 тоот тушаалаар “Байгалийн хий, хийн хөгжлийн хөтөлбөр боловсруулах” ажлын хэсэгт УУХЯ-ны Металл бус хүнд үйлдвэрлэлийн хэлтсийн /хуучнаар/ дарга Б.Анхбаяр, ННБХҮҮБ ТХН-ийн захирал Ж.Очир нар ажиллаж байна. 2.Төсөл хэрэгжих бүс нутгийн байгаль орчны үнэлгээний тайланг 2-р сард хүлээн авсан бөгөөд тайлангийн 	70	

			<p>төслийн олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг 2019 оны 2 дугаар сарын 19-нөөс 25-ны өдрүүдэд Нийслэлийн 4 дүүрэг, Төв аймгийн 6 суманд амжилттай зохион байгуулсан. Дэлхийн банкны стандарт, шаардлагад нийцсэн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний эцсийн тайланг 2019 оны эхний хагаст хүлээн авна. УУХҮЯ-ны ТНБД-ын 2019 оны 4 дүгээр сарын 30-ны 03/226 тоот адбан бичгээр БОАЖЯ-ны ТНБД-д хандан ТХН-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор БОҮнэлгээг батлуулах тухай албан бичиг илгээсэн.</p> <p>3.Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс Багануурын уурхайн удирдлага мэргэжилтэнүүдэд төслийг танилцуулга хийгдсэн. Багануурын нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Уурхайн хүчин чадлын нөөцийн боломжит судалгааг төсөлтэй хамтран хийсэн ба тус уурхай нь Дэлхийн банкны санхүүжилтээр нэмэлт хайгуул хийж, нөөцийг шинэчлэн тогтоолгож, ашигт малтмалын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл болон Грийнтрендс ХХК хамтран “Багануурын нүүрсний уурхайн бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайлангийн төсөл”-ийг танилцуулах олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг 2019 оны 06 дугаар сарын 26 өдөр зохион байгуулна.</p> <p>4.Төв аймгийн Баяндэлгэр сумын ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн шийдвэрээр “Сумын газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөө”-нд оруулан баталж, газрын асуудлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах тухай Төв аймгийн ИТХ-ын 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 08 тоот тогтоолоор хий дамжуулах шугам хоолойн трассын байршлыг нарийвчлан тогтоож, хий дамжуулах хоолой дайран өнгөрөх газрыг тусгай хэрэгцээнд авах ажлыг дэмжих тухай шийдвэр гарсан.</p>		
96	2	2	<p>2016_114. АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАХ ТУХАЙ”ЗЭСИЙН БАЯЖМАЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” БАРЬЖ БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ</p>	<p>Ерөнхий сайдын 2016 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" 114 дүгээр захирамжаар "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр" барьж байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт</p>	30

			<p>ТАЛААР ХЭЛЭЛЦЭЭ ХИЙЖ, САНАЛ, ДҮГНЭЛТ БОЛОВСРУУЛАХ / 2016-11-22 /</p> <p>2. Ажлын хэсгийн баримтлан ажиллах удирдамжийг хавсралт ёсоор баталж, төслийн хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийж санал, дүгнэлт боловсруулан, дүнг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Дашдорж)-т даалгасугай.</p>	<p>боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж дүгнэлт гаргасан. Үүнд:</p> <p>1. Хатчийн судалгааны тайлан, салбарын яамнаас ирсэн дүгнэлтийг үндэслэн Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт барих асуудлыг ЗГ-ын хуралдаан оруулж шийдвэрлүүлэх;</p> <p>2. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр эзэмших тухай УУХҮЯ-ны саналыг ЗГ-ын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх;</p> <p>3. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагчтай гэрээ хэлцэл хийх ажлыг эрчимжүүлж үр дүнг 2017 оны II улиралд багтаан Засгийн газарт танилцуулах асуудлыг ЗГ-аас гаргах тогтоолд тусгаж шийдвэрлэх.</p> <p>Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн ЗГ-ын тогтоолын төслийг боловсруулан зохих журмын дагуу ЗГ-ын 2017.03.15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" 88 дугаар тогтоол батлагдан бөгөөд тус тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Түүнчлэн тус үйлдвэрийг байгуулах тухай асуудлыг ҮАБЗ-өөр хэлэлцүүлж, зөвлөмж гарсан бөгөөд ЗГ-ын 2019.05.17-ны өдрийн "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" 196 дугаар тогтоолоор ЗГ-ын 2017.09.13-ны өдрийн 247 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-д хамруулж нэн чухал асуудлаар анхааран ажиллаж байна.</p>		
4.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл						
97	1	1	<p>2016_29. 2016 ОНЫ 05 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР 29 ДҮГЭЭР ТЭМДЭГЛЭЛ</p> <p>XXXI.3. Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат "Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" Засгийн газрын 2015 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 247 дугаар тогтоолын хэрэгжилтийн явц, Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох тухай асуудлыг Засгийн газрын гишүүдэд</p>	<p>Хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах ажлын хэсгийн дагаж мөрдөх журам, хөрөнгө оруулагчид тавигдах шаардлага, Хөрөнгө оруулагчын гэрээний төсөл боловсруулах ажлыг тус төслийн хуулийн зөвлөх компаниар "Таван Лекс" ХХН гэрээний дагуу гүйцэтгүүлэн тайланг хүлээн авсан. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, уг төслийг хэрэгжүүлэгч нэгжид дэмжлэг үзүүлэх зорилгоор төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулахад хууль, санхүүгийн гадаад, дотоодын зөвлөхийг сонгон шалгаруулах</p>	70	<p>Засгийн газрын 2015.06.15-ны өдрийн 247 дугаар тогтоолыг хүчингүй болгосон тул ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ.</p>

			<p>танилцуулав. Үүнтэй холбогдуулан хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган уг асуудлаар тогтоолын төсөл боловсруулж, зохих журмын дагуу холбогдох байгууллагаас санал авсны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад даалгав.</p>	<p>тендерийг 2018.08-10 сард зохион байгуулсан. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах хууль, санхүүгийн зөвлөх үйлчилгээний гэрээг “Өмгөөллийн Монгол өмгөөлөгч” ХХН-тэй байгуулсан бөгөөд явцын тайланг хүлээн аваад байна. Улмаар хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулсны дараа "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр"-ийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн хувийг хөрөнгө оруулагчтай эцэслэн тохиролцох юм. Засгийн газрын 2017 оны "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" 88 дугаар тогтоолоор Засгийн газрын 2015 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 247 дугаар тогтоолыг хүчингүй болгосон тул хяналтаас хасах саналтай.</p>		
98	2	2	<p>2018_15. 2018 ОНЫ 3 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР 15 ДУГААР ТЭМДЭГЛЭЛ /2018-03-27/</p> <p>ХХIX.14. Монгол Улсад алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудалтай холбогдуулан хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх үндэслэл, тооцоог гаргасны үндсэн дээр аж ахуйн нэгж байгуулах тухай шийдвэрийн төсөл боловсруулан хууль тогтоомжийн хүрээнд Монголбанк болон яамдын саналыг авч, Засгийн газрын хуралдаанд зохих журмын дагуу оруулж хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав.</p>	<p>Улсын Их Хурлын Байнгын хорооны 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн “Чиглэл өгөх тухай” 32 дугаар тогтоолд “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.69 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд 2019 онд багтаан дотооддоо алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ү.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/-нд чиглэл болгосны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А-303 тогтоолоор Монгол Улсад алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлын цогц төлөвлөгөө боловсруулах, холбогдох тооцоо судалгаа хийж танилцуулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын хуралдаанаар алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлаар хэлэлцэж “Стратегийн ач холбогдолтой том төслийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тэмдэглэл гарсан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдөр алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлаар “Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах тухай” хэвлөмж гарсан. Тус зөвлөмжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Тагнуулын ерөнхий газраас Засгийн газрын хэрэг эрхлэх газарт алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлыг нууцад хамруулах асуудлаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар зохих журмын дагуу хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх тухай албан бичгийг 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр хүргүүлэн</p>	70	

				Засгийн газрын 2019.05.17-ны өдрийн "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" 196 дугаар тогтоолоор Засгийн газрын 2017.9.13-ны өдрийн 247 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-д хамруулж нэн чухал асуудлаар анхааран ажиллаж байна.		
99	3	3	<p>2018_25. 2018 ОНЫ 6 ДУГААР САРЫН 6-НЫ ӨДӨР 25 ДУГААР ТЭМДЭГЛЭЛ /2018-06-06/</p> <p>ХҮ1.3. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-импорт банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийн явцыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн сонголт болон бусад асуудлаар Энэтхэгийн талтай хэлэлцэн эцэслэн тохиролцож, дүнг Засгийн газрын дараагийн хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав.</p>	Төслийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр Энэтхэгийн "Инженерс индиа лимитед" компани шалгарч, УУХҮЯ болон "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-тай зөвлөх үйлчилгээ үзүүлэх гурвалсан гэрээг 2017.08.09-ний өдөр байгуулсан. Захиалагч УУХҮЯ, төсөл хэрэгжүүлэгч "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК компани болон захиалагчийн инженер Итали Улсын "КТ-Кинетикс" компанийн зүгээс нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажилласан бөгөөд эцсийн тайланг УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2018.11.15-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан.	70	
100	4	4	<p>2018_26. 2018 ОНЫ 6 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР 26 ДУГААР ТЭМДЭГЛЭЛ /2018-06-13/</p> <p>ХИХ.10. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийн явцын талаарх Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын танилцуулгыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 10.1. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-ээр тооцоолсон</p>	Төслийн нарийвчилсан ТЭЗҮ-ийн дундын буюу явцын тайланг 2018 оны 02 дугаар сард ирүүлсэнтэй холбогдуулан БНЭУ-ын Зөвлөх түүнд хөндлөнгийн хяналт тавьж буй Итали Улсын "КТ-Кинетикс" компаниуд Монгол Улсад 2018 оны 04 дүгээр сарын 22-26-ны өдрүүдэд албан айлчлал хийж, гурван талт техникийн зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулсан. Энэхүү уулзалтаар захиалагч буюу УУХҮЯ болон "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн зүгээс БНЭУ-ын Зөвлөхийн гүйцэтгэсэн тайланд санал болгосон технологийн сонголт, төсөвт өртгийн тооцоог дахин нягтлах шаардлагатай байгаа тухай санал, зөвлөмжийг хүргүүлсэн. Түүнчлэн УУХҮСайдаар ахлуулсан ажлын хэсэг БНЭУ-д 2018 оны 06 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд албан айлчлал хийж, Энэтхэгийн Гадаад хэргийн яам, Экспорт-Импорт банк болон Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй "Инженерс Индиа Лимитед"	100	

			<p>хөрөнгө оруулалтын зардлыг холбогдох гэрээ, хэлэлцээрийн хүрээнд бууруулах арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав.</p>	<p>компанийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, нарийвчилсан ТЭЗҮ-ийн ажлын явц, үйлдвэрийн технологийн сонголт болон төсөвт өртгийн талаар тус тус санал солилцсон. Айлчлалын үр дүнд Энэтхэгийн тал Монголын талын санал болгосон технологийг сонгохоор болж, үйлдвэрийн хөрөнгө оруулалтыг хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан 1 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд багтаан дахин тооцоолол хийхээр нэгдсэн ойлголцол, тохиролцоонд хүрсэн. Гэвч зөвлөх компанийн зүгээс НТЭЗҮ-ийн тооцоололд Монголын талын тавьсан шаардлагын дагуу нэмэлт тооцоо судалгааг тусган ирүүлээгүй тул УУХҮСайдын санаачлагаар Энэтхэгийн талтай дахин зөвшилцөх уулзалтыг Улаанбаатар хотноо 2018.09.27-ны өдрөөс 10 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулсан. Уг уулзалтаар Энэтхэгийн тал боловсруулах үйлдвэрийн хөрөнгө оруулалтын зардлыг тодорхой хэмжээгээр бууруулах боломжтой талаар дурдан захиалагчийн санал болгосон технологийг сонгохоор болсон бөгөөд түүхий тос дамжуулах хоолойн хувьд Монгол улстай ижил төстэй нөхцөлд буюу ОХУ, БНХАУ-д ашиглагдаж байгаа уламжлалт технологийг судлахаар тохиролцсон. Үйлдвэрийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл бэлэн болсонтой холбогдуулан төслийн менежментийн зөвлөх компанийг хоёр улсын хооронд байгуулсан 1.0 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрт заасны дагуу сонгон шалгаруулсан бөгөөд Энэтхэг Улсын Засгийн газрын зүгээс тус улсын төрийн өмчит “Инженерс Индиа Лимитед” компанийг төслийн зөвлөхөөр сонгосон. Төслийн менежментийн зөвлөх компаниар шалгарсан Энэтхэгийн “Инженерс Индиа Лимитед” төрийн өмчит компани болон “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК нар зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг 2019.05.13-ны өдөр байгуулсан. Батлагдсан ТЭЗҮ-ийн дагуу уг үйлчилгээний зардлыг 100 орчим сая америк доллар байхаар урьдчилан тусгагдсан байсныг хэлэлцээр хийсний үр дүнд гэрээний үнийн дүнг 72.3 сая ам.доллар болгож бууруулсан.</p>		
101	4	5	<p>XIX.10.2. Түүхий тос дамжуулах хоолойг нарийвчилсан ТЭЗҮ-ээр тооцоолсон</p>	<p>Түүхий тос дамжуулах хоолойг нарийвчилсан ТЭЗҮ-ээр тооцоолсон хөрөнгө оруулалтын зардлаас бага өртөгтэйгээр Оросын Холбооны Улс болон Бүгд</p>	70	

			хөрөнгө оруулалтын зардлаас бага өртөгтэйгээр Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хэрэглэгдэж байгаа уламжлалт технологийг ашиглан байгуулах санхүүжилтийн болон техникийн боломжийг судалж, танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт үүрэг болгов.	Найрамдах Хятад Ард Улсад хэрэглэгдэж байгаа уламжлалт технологийг ашиглан байгуулах санхүүжилтийн болон техникийн боломжийг шийдвэрлэхэд Засгийн газрын баталгаа зайлшгүй шаардлагатай байгаа тул Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн зүгээс түүхий тос дамжуулах хоолойн асуудлыг Засгийн газар болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулахаар бэлтгэж байна.		
102	4	6	10.4. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав.	УУХҮСайдын 2018.12.18-ны өдрийн А/259 дугаар тушаалаар “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн дүрмийг шинэчлэн баталсан бөгөөд тус дүрмийн 12.2-д Өмчлөгчийн хяналтыг Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлэхээр тусгасан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019.01.15-ны өдрийн А/06 дугаар тушаалаар Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулан газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	100	
103	5	7	2018_48. 2018 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДӨР 48 ДУГААР ТЭМДЭГЛЭЛ /2018-11-21 / XII. Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав: 2.1. үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжийн бүтээн байгуулалтын ажлын явцыг Засгийн газарт танилцуулах; 2.2. үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг зохих журмын дагуу дүгнэсний үндсэн дээр гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, газрыг зориулалтын бусаар эзэмшиж, ашиглаж байгаа аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг цуцлах, газрыг чөлөөлөх арга хэмжээ авах; 2.3. ашигт малтмал, газрын тосны салбарт олгосон хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг бусдад дамжуулан худалдаж байгаа эсэхийг шалгаж, тусгай зөвшөөрөл	Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан доорх байгууллагуудаас УУХҮ-ийн сайдтай байгуулсан “Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлагатай байгуулах гэрээ”-ний хэрэгжилт, 2018 онд хэрэгжүүлсэн ажлууд, 2019 оны төлөвлөгөөг хүлээн авсан. Үүнд: 1. “Баянговь нутаг үйлдвэрлэл, технологийн парк” ХХК 2. “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨААТҮГ 3. “Дархан үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨХХК 4. “Эрдэнэт технопарк” ХХК 5. “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ Дээрх гэрээний хэрэгжилтийг дүгнэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар бэлтгэж байна. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан бөгөөд Эдийн засгийн байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлын жагсаалтад тусгагдсан. 2.3. 2014.07.01-ний өдөр шинэчлэгдэн батлагдсан Газрын тосны тухай хуулийн 7.1.8 болон 14 дүгээр зүйлд заасныг тус тус үндэслэн газрын тосны хайгуулын Борзон	70	

			олголтыг цэгцлэх асуудлаар санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, дүнг Засгийн газарт танилцуулах.	ҮII талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан “М Си Эс Петро лимитед” ХХК-ийн эрх, үүргийг “Импайргаз монголиа” ХХК-д Монгол Улсын Засгийн газрын 2014.08.20-ны өдрийн 265 дугаар тогтоол, Богд IV, Онги V талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан “БиЖи Монголиа Холдингс Лимитед” ХХК-ийн эрх, үүргийг “Сентриал Азиан Петролеум Корпораци Лимитед” ХХК-д Засгийн газрын 2016.12.07-ны өдрийн 181 дүгээр тогтоол, Эргэл XII талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан “Смарт ойл инвестмент ЛТД” ХХК-ийн эрх, үүргийг “Смарт петролеум инвестмент ЛТД” ХХК-д Засгийн газрын 2018.04.25-ны өдрийн 108 дугаар тогтоолоор тус тус шилжүүлсэн. Газрын тосны тухай хуулийн 7.1.8 дугаар зүйл буюу “бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах, цуцлах эрхийг олгох, бүтээгдэхүүн хуваах гэрээгээр гэрээлэгчийн хүлээсэн эрх, үүргийг шилжүүлэх” асуудал нь Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэгдэх бөгөөд гэрээлэгч эрх, үүргээ бусдад шилжүүлэх асуудлыг мөн хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар зохицуулдаг.		
104	6	8	2019_8. 2019 ОНЫ 2 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР 8 ДУГААР ТЭМДЭГЛЭЛ /2019-02-08/ XIII.3. . “Таван толгой түлш” ХХК-ийн түүхий эд болох эрчим хүчний баяжуулсан нүүрс (мидлинг)-ийг нөөцлөх дундын агуулах талбайг Улаанбаатар хот, Төв аймгийн нутагт сонгон 1 жилийн хэрэгцээнд зориулан 800.000 хүртэл тонн нөөцийг татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт даалгав.	“Тавантолгой түлш” ХХК нь Төв аймгийн Сэргэлэн сумын Гүн бүрдийн аманд 12 га газрыг 15 жилийн хугацаатай эзэмших гэрээ байгуулж, бүрэн хашаажуулсан. Уг газар дээр 100-120 тоннын даацтай автожин /пүү/ болон харуулын байрыг байршуулсан. Түүхий эд тээвэрлэх тээврийн хэрэгслүүдийн орох гарах гарц, 00 болон бохирын цооног, хогийн цэг, явган хүний 2 хаалга, онцгой тохиолдолд ашиглах 1 хаалга зэрэг тохижилтын ажлыг хийж дуусган түүхий эд /мидлинг/-ийг татан буулгахад бэлэн болсон.	30	
Хэсгийн дундаж. 65.6%						
САЛБАР ЧИГЛЭЛ: 5. НИЙТЛЭГ АСУУДАЛ						
5.а. Монгол Улсын хууль						
5.б. УИХ-ын тогтоол						
105	1	1	2017_69. МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ	Төрийн албан хаагчийн сахилга, хариуцлага, үйл ажиллагааны үр дүн болон хөдөлмөрийн гэрээг хагас,	100	

			<p>БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2017-11-14</p> <p>1.1/Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуульд бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарын багцад “сахилга, хариуцлага, ажлын үр дүнг урамшуулах” зориулалтаар батлагдсан хөрөнгийг зарцуулахтай холбогдуулан төрийн албан хаагчийн сахилга, хариуцлага, үйл ажиллагааны үр дүн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэх, ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үр дүнд үндэслэн урамшуулах тогтолцоог бий болгох, энэ талаар холбогдох журам баталж мөрдүүлэх</p>	<p>бүтэн жилээр үнэлж, дүгнэх, ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үр дүнд үндэслэн урамшуулах тогтолцоог Төрийн албаны тухай хууль Төрийн албаны зөвлөлөөс баталсан дүрэм журамд нийцүүлэн дотоод журамдаа тусган, хэрэгжүүлж ажиллаж байна. 2019 оны хагас жилийн байдлаар сахилгын шийтгэл авсан хүн байхгүй байна.</p>		
5.в. УИХ-ын Байнгын хорооны тогтоол						
5.г. Ерөнхийлөгчийн зарлиг						
106	1	1	<p>МОНГОЛ БААТАРЛАГ ТУУЛЬСАА ДЭЭДЛЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ ТУХАЙ 2019-01-29 №2019_13.</p> <p>3. Баатарлаг туульсаа дээдлэн хамгаалах, бүртгэн судлах, өвлөн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх, олон улсад сурталчлан таниулах, туульч, өвлөн уламжлагч, өв тээгчид болон судлаачдыг урамшуулах үйл ажиллагааг дэмжиж ажиллахыг төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосугай.</p>	<p>УУХҮСайд Д.Сумъяабазар “Монголын геологи ба ашигт малтмал” хэмээх 8 боть бүтээл бүтээн Төрийн соёрхол хүтсэн нэр бүхий 8 эрдэмтдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлж үнэ бүхий зүйлээр 2019.01.17-ны өдөр шагнаж урамшуулсан.</p>	100	
107	1	2	<p>4. Монгол баатарлаг туульсынхаа агуулга, ач холбогдлыг таньж ойлгох, дэмжин дэлгэрүүлэх, өв соёлоо хүндэтгэн дээдлэх, хадгалах, уламжлуулан хамгаалах үйлсэд идэвх санаачлагтай оролцохыг төрийн ба төрийн бус байгууллага, иргэд олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллагуудад уриалсугай.</p>	<p>УУХҮСайд Д.Сумъяабазар “Монголын геологи ба ашигт малтмал” хэмээх 8 боть бүтээл бүтээн Төрийн соёрхол хүтсэн нэр бүхий 8 эрдэмтдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлж үнэ бүхий зүйлээр 2019.01.17-ны өдөр шагнаж урамшуулсан.</p>	100	
5.д. ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл						

<i>5.е. Засгийн газрын тогтоол</i>						
108	1	1	<p>2017_377. ГАДААДААС 2019 ОНД АВАХ АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТНИЙ ЭЗЛЭХ ХУВИЙГ ТОГТООХ ТУХАЙ /2018-12-12/</p> <p>3.Аж ахуйн нэгж, байгууллагын гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтнийг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулж байхыг ажил олгогчид, үзлэгийг зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэлд үүрэг болгосугай.</p>	<p>Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.6 дахь заалтын дагуу гадаадаас ажиллах хүч оруулж ирэх хүсэлт ирүүлсэн нийт 29 ААН-ийн 43 удаагийн хүсэлтийг, холбогдох материалын хамт судлан БНХАУ, Австрали, ХБНГУ, ӨАБНУ, БНЭУ, Канад, Финлянд, Их Британи, Япон зэрэг Улс орноос нийт 270 хүнийг түр хугацаанд Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэх талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газарт уламжилсан.</p>	100	
109	2	2	<p>2019_23. 2019 ОНЫГ “ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ” БОЛГОХ ТУХАЙ /2019-01-16/</p> <p>3. Хавсралтаар төлөвлөгөөг оруулав. “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг эрхлэх ажлын хүрээ, харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж, ажлын тайланг улирал тутам Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. Жич: Хавсралтаар оруулсан “ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-ний дагуу өөрийн нэр заасан ажлыг хүснэгтээр гаргаж тайлагнана.</p>	<p>Засгийн газрын 2019 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн ажлын тайланг 2019 оны нэгдүгээр улирлын байдлаар болон 05 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар гаргаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. 2019 оны хоёрдугаар улиралын байдлаар тайланг нэгтгэн 07 дугаар сарын 01-ны өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхээр ажиллаж байна.</p>	100	
110	3	3	<p>2019_33. ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ /2019-01-23/</p> <p>2.Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай.</p>	<p>УУХҮЯ-ны ТНБД-ын 2016 оны Б/52 дугаар тушаалаар баталсан хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг 2019 оны А/12 тушаалаар байгуулан 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга болон түүнд үндэслэн гарсан бусад шийдвэртэй уялдуулан шинэчилж 2019.06.10-ны өдөр боловсруулж, батлуулахад бэлэн болгож удирдлагад танилцуулж байна.</p>	70	

111	4	4	<p>2019_59. 2019 ОНЫГ “ЭХ ОРОНЧ ХУДАЛДАН АВАЛТЫН ЖИЛ” БОЛГОХ ТУХАЙ / 2019-01-30 /</p> <p>3. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан төлөвлөгөөнд тусгасан ажлын хүрээнд нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, эрхэлсэн салбар, харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжилтийг зохион байгуулж, тайланг хагас болон жилийн эцсийн байдлаар Аж үйлдвэржилтийн бодлогын зөвлөлд хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай.</p>	Тогтоолын 2 дугаар зүйлд заасан төлөвлөгөөнд тусгасан ажлын хүрээнд нарийвчилсан төлөвлөгөөг УУХҮСайдын 2019.03.17-ны өдрийн А/123 дугаар тушаалаар батлуулж харьяа байгууллагуудад хүргүүлэн, төлөвлөгөөний хэрэгжилтийг Хагас жилийн байдлаар гаргаж ЗГХЭГ-т хүргүүлэхээр удирдлагад танилцуулж байна.	100	
112	5	5	<p>2018_242. ТАВАНТОЛГОЙ-ГАШУУНСУХАЙТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ТӨСЛИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ / 2018-08-08 /</p> <p>6.. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн төрд ногдохоос бусад хувьд хөрөнгө оруулах этгээдийг урьдчилгаа төлбөр, боомт ашиглалт, дамжуулан тээвэрлэлт хийх боломжтой гадаадын хөрөнгө оруулагч нараас судлан, хэлэлцээ хийж, үр дүнг 2018 онд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нар т даалгасугай.</p>	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрдэнэс Тавантолгой ХК-иуд хамтран Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн төрд ногдох хэсэгт хөрөнгө оруулалтын хувь хэмжээг тохирох ажлыг Монголын төмөр зам ЭТТ ХК-дтай хамтран ажиллаж байна.	30	
113	6	6	<p>2018_245. “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ / 2018-08-08 /</p> <p>1.. Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр үе шаттайгаар арилжаалахтай холбогдсон бэлтгэл ажлыг хангахад шаардагдах мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага,</p>	УИХ-ын 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы хуралдаанаар батлагсан Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт “Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээл дээр үнэт цаас гаргах, арилжаалах, олон улсын зах зээл, банк, санхүүгийн байгууллагаас арилжааны нөхцөлтэй зээл авахтай холбоотой үйлчилгээ худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэж тусган батлуулсан. Энэхүү хуулийн зохицуулалт 2019 оны 6 дугаар сарын	30	

		<p>техник, технологи шаардсан үйлчилгээг үзүүлэх чадвартай гүйцэтгэгчийн тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт, холбогдох гэрээг байгуулан хэрэгжүүлж ажиллахыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт тус тус даалгасугай.</p>	<p>01_ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын болон Компаний гүйцэтгэх захирлын тушаалаар ажлын хэсэг, компанийн бүтцэд хувьцаа (IPO) хариуцсан газар, нэгжийг байгуулан ажиллаж байна.</p> <p>Хувьцаа (IPO) гадаад зах зээлд арилжих хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Тавантолгойн ордын өргөтгөсөн нөөцийн нэгтгэл тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, бүртгүүлсэн байна. Энэхүү нөөцийн нэгтгэл тайлангаар Тавантолгойн ордын нүүрсний нөөцийг 300 сая тонноор нэмэгдүүлсэн болно. Нэмэгдэж батлагдсан нөөцөд тулгуурлан ордыг иж бүрэн ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж эхлээд байна. • Засгийн газрын 2018 оны 242 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг ажлыг эрчимжүүлэх үүрэг бүхий Төрийн өмчийн тавин нэгээс доошгүй хувийн оролцоотой “Таван толгой төмөр зам” ХХК-ийг байгуулсан болно. • Засгийн Газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хуралдаанаар Оюу толгой төслийг эрчим хүчээр хангах цахилгаан станц барих тухай гэрээнд гарын үсэг зурах эрхийг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга А.Тлейхан нарт олгосны дагуу 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Эрчим хүчний яам болон “Оюу толгой” ХХК Тавантолгойн цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулах “Эрчим хүчний эх үүсвэрийн зохицуулалтын тухай гэрээ”-нд гарын үсэг зурсан. <p>Үнэт цаас гаргах бэлтгэлийг хангах хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, компанийн засаглал, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй эдийн засгийн төслүүд, богино, дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж, талуудад хүргэхийн зэрэгцээ зах зээлийн болон хөрөнгө оруулагчдын сонирхлын талаарх судалгааны ажлыг гүйцэтгэх, зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгч мэргэжлийн оролцогчдыг сонгох, хамтарч ажиллах хувилбарыг боловсруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна. “Эрдэнэс Тавантолгой”</p>		
--	--	---	--	--	--

				ХК-ийн хувьцааны тодорхой хэсгийг гадаад зэх зээлд арилжиж хөрөнгө оруулалтыг эрчимжүүлсэнээр шаардлагатай дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэн олборлолт, баяжуулалт, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх юм. Ингэснээр компанийн орлого, үнэ цэнэ нэмэгдэж, төр, иргэн, аж ахуй нэгжийн эзэмшиж буй хувьцаа эдийн засгийн эргэлтэд орох боломж бүрдэх юм.		
114	7	7	<p>2018_304. ХОРИХ АНГИ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР ТАТАН БУУЛГАХ ТУХАЙ / 2018-10-10 /</p> <p>2. Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын “Нүүрстэйн ам” нэртэй газарт байрлах 83 га, Төв аймгийн Лүн сумын “Авдрант” нэртэй газарт байрлах 31 га бүхий уурхайн талбай болон тэдгээрийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Ашигт малтмал, газрын тосны газарт тус тус буцаан өгөхийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Ц.Амгаланбаярт, уурхайн талбайг хүлээн авахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэнд тус тус даалгасугай.</p>	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 304 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 892 дугаар шийдвэр гарсан бөгөөд тус шийдвэрээр Кадастрын хэлтсийн талбай буцааж хүлээлгэн өгөх өргөдлийн бүртгэлийн SF-003235 дугаарт бүртгэгдсэн өргөдлийн дагуу “Хорих 443-р анги” УУГ-ын эзэмшилд буй Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Нүүрстэй нэртэй 81.53 гектар талбай бүхий МВ-001356 дугаартай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг буцаан хүлээн авсанд тооцож, тусгай зөвшөөрөл болон зураг зүйн бүртгэлд бүртгэж шийдвэрлэсэн. Мөн АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 876 дугаар шийдвэр гарсан бөгөөд тус шийдвэрээр Кадастрын хэлтсийн талбай буцааж хүлээлгэн өгөх өргөдлийн бүртгэлийн SU-003234 дугаарт бүртгэгдсэн өргөдлийн дагуу Төв аймгийн Лүн сумын “Авдрант” нэртэй газарт байрлах 31 гектар талбай бүхий МВ-005485 дугаартай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг буцаан хүлээн авсанд тооцож, тусгай зөвшөөрлийн болон зураг зүйн бүртгэлд бүртгэж шийдвэрлэсэн.	100	Тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгавар хэрэгжсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.
115	8	8	<p>2019_111. ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ / 2019-03-21 /</p> <p>2.. Бүх шатны төсвийн байгууллага, төрийн буюу орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг тогтоосон хувь хэмжээгээр ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд зохих төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.</p>	МУ-ын Ерөнхийлөгчийн 128 дугаар зарлигийн дагуу бичил уурхай дахь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг таслан зогсоох, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор УУХУСайдын “Хүний эрх, хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажиллах тухай” 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 06 тоот албан даалгаврыг 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 03/3384 тоот албан бичгээр орон нутгийн Засаг дарга, холбогдох газар нэгж, агентлаг болон салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудад хүргүүлсэн. Албан даалгаврын хэрэгжилтийг хангах зорилгоор ГУУХУ-ийн салбарын	70	

				нийгмийн зөвшлийн 2019-2020 оны хамт /тариф/- ын хэлэлцээрийн 2.12 дахь заалтад “Аж ахуйн нэгж бүр Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр заалтыг хэрэгжүүлж ажиллуулна” гэсэн заалтыг нэмж тусган баталгаажуулж ХНХЯ-наас 2019 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр бүртгэсэн.		
<i>5.ё. Ерөнхий сайдын захирамж</i>						
116	1	1	08_2014_61. ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ, САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН БАТЛАХ ТУХАЙ / 2014-05-16 / 2. Нээлттэй засгийн түншлэлийн ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Үндэсний зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нарийн бичгийн даргад даалгасугай.	Үндэсний зөвлөл нь салбар зөвлөлийн ажлыг нэгтгэж тайлагнах тул яамнаас биелэлт гаргах шаардлагагүй.	/-/	
<i>5.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл</i>						
117	1	1	2016 оны 10 дүгээр сарын 26-ны өдөр 52 дугаар тэмдэглэл / 2016-10-26 / №52 XIII.1.2. хөрөнгө оруулагчид, аж ахуй эрхлэгчдэд төрийн захиргааны болон хуулийн байгууллагаас хууль бусаар дарамт учруулсан, хүнд суртал гаргасан, үндэслэлгүйгээр мөрдөн шалгасан асуудлыг судалж гаргасан дүгнэлтэд тусгагдсан асуудлыг шийдвэрлэх ажлыг шуурхай зохион байгуулж, хөрөнгө оруулагчид, аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаанд саад учруулж байгаа хууль бус дарамт, шаардлагуудыг арилгаж, хүчингүй болгох арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт.	Хөрөнгө оруулагчид, аж ахуй эрхлэгчдэд төрийн захиргааны болон хуулийн байгууллагаас хууль бусаар дарамт учруулсан, хүнд суртал гаргасан, үндэслэлгүйгээр мөрдөн шалгасан асуудал гарч буй эсэхийг тогтмол судалж байгаа ба дурдсан нөхцөл байдал үүсээгүй болно.	100	
118	2	2	2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр 3 дугаар тэмдэглэл / 2019-01-16 / №2019_3. I. Монгол Улсын Засгийн газраас зарласан “Хариуцлагын жил”-ийн хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын	1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцаас 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Тендерийн үнэлгээний хороог 2019.01.21-ний өдрийн А/16 дугаар тушаалаар байгуулж, тендерийг зарлан дүгнэж байна. Тендерийн	70	

		<p>дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав:</p> <p>1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг хуулийн дагуу төлөвлөгөө гарган, шилэн дансанд байршуулах замаар 2019 оны I улиралд багтаан олон нийтэд ил тод, шуурхай зохион байгуулах;</p> <p>2. Төрийн болон нутгийн удирдлагын бүх шатны байгууллагууд баталсан дүрэм, журамдаа шинжилгээ хийж, иргэд, олон нийтээр хэлэлцүүлэн, байгууллага, иргэдэд хүнд суртал, чирэгдэл үүсгэж байгаа дүрэм, журмыг хүчингүй болгох арга хэмжээ авч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт мэдээг хагас, бүтэн жилээр ирүүлэх;</p> <p>3. Төрийн байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлээгүй төрийн албан хаагч, албан тушаалтанд хариуцлага тооцож, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээнд тусгаж байх;</p> <p>4. Төрийн албан хаагч ажлын болон ажлын бус цагаар ажлын байр, томилолтын явцад согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох талаар тогтоосон дэг журмыг чанд мөрдүүлэх, журмыг зөрчсөн албан хаагчтай тухай бүр холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож байх;</p> <p>5. Яам, агентлагийн бодлого, шийдвэрийг бусад байгууллага болон олон нийтэд ил тод мэдээлэх, тусгай зөвшөөрөл олгох ажлыг цахимжуулах арга хэмжээ авах;</p> <p>6. Төрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийцүүлэн төрийн албан</p>	<p>явцын мэдээллийг сар бүр Сангийн яаманд хүргүүлж, Шилэн дансанд байршуулан ил тод байдлыг ханган ажиллаж байна.</p> <p>2. Засгийн газрын 2016 оны 350 дугаар тогтоолоор баталсан “Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх зорилгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/33 дугаар тушаалаар “Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын чиг үүргийн шинжилгээ хийх, дахин хуваарилах, холбогдох санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг”, мөн Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх зорилгоор Техникийн дэд ажлын хэсгийг УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/67 дугаар тушаалаар байгуулсан. Дэд ажлын хэсэг нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 681 хуулиас Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын 5 ерөнхий, 11 үндсэн, 34 дэд чиг үүргээр бусад яам, агентлаг, Засгийн газрын бүтцийн байгууллагууд болон нийтлэг заалт /хамаарал/ бүхий 241 хуулийн хүрээнд хуулиудын давхардал, хийдэл, зөрчил, санхүүгийн шинжилгээ болон төрийн чиг үүргийг дахин хуваарилах шинжилгээг санал, дүгнэлтийг боловсруулан 2019 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Зөвлөлдөх ажлын хэсэгт танилцуулсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу дараагийн шатны ажлуудыг гүйцэтгэн 2019 оны 07 дугаар сард багтаан тайланг эцэслэн боловсруулахаар дэд ажлын хэсэг ажиллаж байна.</p> <p>3. ЗГ-ын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол болон бусад хууль тогтоомжийн дагуу УУХҮЯ, АМГТГ-т байгууллага, иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг бүртгэн авч, судалж шийдвэрлэн хуулийн хугацаанд хариу өгч ажиллаж байна. 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 260 өргөдөл, гомдол ирснээс албан бичгээр 260 байна. Эдгээрээс шийдвэрлэж хариу өгсөн 229, хугацаа болоогүй 30, хугацаа хэтэрсэн 1 өргөдөл ба шийдвэрлэлт 99.6%-тай байгаа ба хагас жилийн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээ хуулийн дагуу 7 дугаар сарын 10-ны дотор багтаан холбогдох газарт хүргэгдэнэ.</p> <p>4. Дээрх заалтыг хөдөлмөрийн дотоод журмын шинэчилсэн найруулгад тусгасан. Одоогоор энэ төрлийн зөрчил илрээгүй байна.</p>		
--	--	---	---	--	--

			<p>хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг сар бүр дүгнэж ажиллах;</p> <p>7. Төрийн бүх шатны байгууллагын салбар, нэгжийн ажлын уялдаа, бүтээмжийн үнэлгээг тодорхой болгох;</p> <p>8. Төрийн албан хаагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг хууль хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулах, хууль зөрчсөн албан хаагчдад заавал хариуцлага тооцож байх;</p> <p>9. Төрийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагын ажлын үр дүнг иргэдийн сэтгэл ханамжийн үзүүлэлттэй холбон дүгнэх үнэлгээний журам тогтоох.</p>	<p>5. Салбарын бодлого болоод тусгай зөвшөөрлийн мэдээллийг холбогдох мэргэжилтнүүд хэвлэлийн ажилтанаар дамжуулан тогтмол сайтад байршуулан ажиллаж байна. http://mmhi.gov.mn/ Мөн ил тод хариуцлагатай уул уурхай хэвлэлийн бага хурлыг сар бүр зохион байгуулж байгаа ба хагас жилийн байдлаар нийт 4 удаа зохион байгуулагдсан.</p> <p>6. МУ-ын сайд, ЗГХЭГ-ын даргын 2019.06.04-ний өдрийн 47-р тушаалаар Байгууллагын болон ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний загвар батлагдаж загварын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах ажил хийгдэж байна.</p> <p>7. Салбарын уялдаа холбоог хангах үүднээс “хүний эрх, хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажиллах тухай” 2018.12.04 №06, Сахилга, хариуцлага дэг журмыг чангатгах тухай 02, 03 сайдын албан даалгавар гаргуулан харъяа байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>8. ХЗДХ-аас ирүүлсэн бичгийн дагуу Зөвлөл байгуулахаар төсөл <u>2019.05.15</u> боловсруулан дэд сайдад танилцуулагдаж байна.</p> <p>9. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/20 дугаар тушаалаар байгуулагдсан “Эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах” тендерийн үнэлгээний хороо сонгон шалгаруулалтыг хийж гүйцэтгэсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 7-ны өдрийн А/02 дугаар тушаалаар батлагдсан жагсаалтын дагуу эрдэм шинжилгээ, судалгааны ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн Хэрэглэгчийн үнэлгээ буюу Багц 7-д цахимаар ирүүлсэн саналыг хянаж, чанарын үнэлгээний аргаар үнэлэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 38.3-т заасан шаардлагыг ханган хамгийн өндөр оноо авсан зөвлөхөөр “Монголын эрхзүйн орчны хөгжлийн холбоо ТББ” шалгарсан тул ТНБД-ын 2019.06.13-ны өдрийн 03/1797 албан тоот бичгээр гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэн. Тухайн шалгарсан зөвлөхтэй гэрээ байгуулахаар ажиллаж байна.</p>		
--	--	--	---	--	--	--

119	2	3	<p>II. Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:</p> <p>1. Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хариуцлагатай, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов:</p> <p>1.1. төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор төрийн бүх шатны байгууллага Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ын дагуу чиг үүргийн шинжилгээ хийж, чиг үүрэг дахин хуваарилах саналаа 2019 оны 12 дугаар сард багтаан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх;</p> <p>1.2. төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилох, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоог нөхөхдөө чадахуйн (мерит) болон шатлан дэвшүүлэх зарчмыг үндсэн шалгуур болгон Төрийн албаны тухай хуулийг чанд баримтлах;</p> <p>1.3. төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа албан тушаалтнуудын судалгаанд үндэслэн Төрийн албаны хуульд заасан шаардлага хангаж байгаа албан тушаалтнуудыг зохих журмын дагуу томилох, шаардлага хангахгүй байгаа албан тушаалтнуудыг үүрэгт ажлаас чөлөөлж, дүнг 2019 оны 3 дугаар сарын 1-</p>	<p>1.1. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 350 дугаар тогтоолоор баталсан “Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн байгууллагын чиг үүргийг дахин хуваарилах аргачлалыг Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж эхлээд байна. Энэ ажлын хүрээнд тус салбарт Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019.02.19-ны А/33 дугаар тушаалаар Ажлын хэсэг, Төрийн нарийн бичгийн даргын 2019.04.11 А/67 дугаар тушаалаар Дэд ажлын хэсэг /Техникийн ажлын хэсэг/ тус тус байгуулагдан ажиллаж байна. Дэд ажлын хэсгийн зүгээс салбарын ерөнхий чиг үүргийн шинжилгээ, үндсэн чиг үүргийн шинжилгээ, дэд чиг үүргийн шинжилгээг хийж 2019.06.20-ны өдөр удьдчилсан байдлаар дууссан бөгөөд холбогдох хууль, эрх зүйн зохицуулалт, захиргааны эрх хэмжээний шинжилгээ, хэрэгжүүлж байгаа түвшинг тодорхойлох ажлууд хийгдэж байна. Дээрх шинжилгээ, тайлангуудыг үндэслэн холбогдох хууль тогтоомжид оруулах нэмэлт өөрчлөлтийн талаарх саналыг Ажлын хэсэг болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын Зөвлөлийн хуралд танилцуулж, салбарын нэгдсэн санал дүгнэлтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхээр ажиллаж байна.</p> <p>1.2. 2019 оны эхний хагас жилд тус яамнаас өөрийн хүсэлтээр шилжин ажиллахаар чөлөөлөгдсөн 4, суралцахаар 1, тэтгэвэр тогтоолгохоор 1, нийт 6 төрийн жинхэнэ албан хаагч чөлөөлөгдсөн. Сул орон тоог Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасны дагуу байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлж, мөн хуулийн 27 дугаар зүйлийг 27.1.1, 27.1.2-ыг баримтлан нөхөн тангараг өргөсөн 5 төрийн жинхэнэ албан хаагчыг томилсон.</p> <p>1.3. Удирдах албан тушаал буюу хэлтсийн даргын сул орон тоог журмын дагуу 2019 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 03/09 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, чадахуйн (мерит) болон шатлан дэвших зарчмын дагуу Ахлах мэргэжилтэн Д.Дамбаар хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгүүлж байна.</p> <p>1.4. Тус яаманд гэрээт ажилтан нэг ч байхгүй байна.</p> <p>1.5. Тус яаманд сүүлийн 10 жил компьютер, техник хэрэгслийг шинэчлээгүй, ашиглалтын хугацаа</p>	70	
-----	---	---	---	--	----	--

		<p>ний өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх;</p> <p>1.4. төрийн захиргааны албан тушаалын байнгын ажлын байранд гэрээт ажилтан ажиллуулж хууль тогтоомж зөрчдөг үйлдлийг таслан зогсоох, ийм гэрээт ажилтны гэрээг цуцалж, уг орон тоог хуульд заасан журмын дагуу нөхөх;</p> <p>1.5. төрийн захиргааны байгууллагын ашиглаж байгаа компьютер, техник хэрэгслийн элэгдлийг тооцон шинэчлэх арга хэмжээг батлагдсан төсвийн багцдаа багтаан үе шаттайгаар хэрэгжүүлэх;</p> <p>1.6. төрийн байгууллагын үйл ажиллагаанд ажлын байрны зураг авалт хийсний үндсэн дээр боломжит үйл ажиллагааг цахимжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;</p> <p>1.7. төрийн албаны хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнийг мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах;</p> <p>1.8. төрийн бүх шатны албан хаагчийг хамруулах сургалтын хуваарийг жил бүрийн 1 дүгээр сард багтаан төлөвлөх, албан хаагчдыг сургалтад хамруулах, хэрэгцээ шаардлага, үр дүн нь тодорхой бус сургалтад оролцуулахаас татгалзах;</p> <p>1.9. Төрийн албаны тухай хууль, холбогдох журамд заасны дагуу төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээг бодитой, үнэн зөв үнэлэх, үнэлгээний дагуу цалин урамшуулал, хариуцлагын асуудлыг хууль, дүрэм, журамд нийцүүлэн хэрэгжүүлж байх;</p> <p>1.10. төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг бодлогын баримт бичигтэй уялдуулах, хагас, бүтэн жилээр явцын хяналт-шинжилгээ хийж үр дүнг албан хаагчдад тогтмол мэдээлж байх;</p>	<p>дууссан байсан. 2019 оны эхний хагас жилд нийт компьютер, техник хэрэгслийн 60 хувийг шинэчилсэн.</p> <p>1.7. Тус яамны Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн нь төрийн байгууллагад тогтвор суурьшилтай 23 жил ажилласан, хүний нөөцөөр мэргэшсэн төрийн жинхэнэ албан хаагч болно.</p> <p>1.8. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны албан хаагчдын 2019 оны сургалтын төлөвлөгөөг 1 дүгээр сард Төрийн нарийн бичгийн дараагаар батлуулсан бөгөөд тус яамны ТНБД-ын 2019.04.09-ний өдрийн А/66 дугаар тушаалаар КОЙКА олон улсын байгууллагын БНСУ-ын Сонгнам хотноо зохион байгуулж буй “Газрын тосны бүтээгдэхүүний чанарын менежментийн систем” сэдэвт сургалтанд 2 албан хаагчийг, ТНБД-ын 2019.05.20-ны өдрийн А/82 дугаар тушаалаар АНУ-ын Колумбын их сургуулаас зохион байгуулж буй “Олборлох салбар ба тогтвортой хөгжил” сэдэвт сургалтанд 2 албан хаагчийг тус тус хамруулаад байна. Түүнчлэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны нийт албан хаагчдад зориулан “Мэдээллийн цаг”-ийн 2019 оны хуваарийг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. “Мэдээллийн цаг”-ийг долоо хоног бүрийн Баасан гарагт зохион байгуулж хэвшсэн. Түүнчлэн нийт албан хаагчдын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 1 сарын хугацаатай 40 цагийн сургалтыг 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 30-ны өдрийг дуустал өдөр бүр өглөө 07:30-09:00 цагийн хооронд ажлын байран дээр зохион байгуулж ажиллаж байна.</p> <p>1.9. МУ-ын сайд, ЗГХЭГ-ын даргын 2019.06.04-ний өдрийн 47-р тушаалаар Байгууллагын болон ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний загвар батлагдаж загварын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах ажил хийгдэж байна. ЗГ-ын 2019.01.23-ны өдрийн 38-р тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 4.1-т зааснаар ТАХ-ийн ажлын гүйцэтгэл, үр дүнд үнэлгээ өгөх “Байгууллагын үнэлгээний баг”-ийг төсвийн шууд захирагчийн шийдвэрээр байгуулахаар шийдвэрийн төслийг боловсруулан хянагдах шатандаа явж байна.</p> <p>1.10. МУ-ын сайд, ЗГХЭГ-ын даргын 2019.06.04-ний өдрийн 47-р тушаалаар Байгууллагын болон ТАХ-ийн</p>		
--	--	---	---	--	--

		1.11. төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг дээшлүүлэн байгууллага, нутаг дэвсгэртээ хууль хэлбэрэлтгүй хэрэгждэг соёлыг тогтоож иргэдийн итгэлийг хүлээсэн, ил тод, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх чиглэлээр өөрийн эрх хэмжээний хүрээнд үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж хэвшүүлэх.	гүйцэтгэлийн төлөвлөгөөний загвар батлагдаж загварын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах ажил хийгдэж байна.		
Хэсгийн дундаж: 81.4%					
НИЙТ ДУНДАЖ: 74.4 ХУВЬ					

Танилцсан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга

Г.Ганхүү

Хянасан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн

Б.Баяржаргал

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн

Д.Батнайрамдал

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн

Д.Болортуяа

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн

Н.Цогтбаяр

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн

Х.Цэнд-Аюуш